

В ХЭСЭГ: СУУРЬ ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ В9: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА АМЬЖИРГААНЫ ТҮВШИН

Агуулга

9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА АМЬЖИРГААНЫ ТҮВШИН	3
9.1 ТАНИЛЦУУЛГА	3
9.2 АРГАЧЛАЛ	3
9.3 ХӨДӨЛМӨР БА АЖЛЫН БАЙРНЫ ОРЧИН НӨХЦӨЛ	4
9.3.1 Монгол улсын стандарт	4
9.3.2 Олон улсын стандарт, конвенциуд	5
9.4 ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ	6
9.4.1 Нийт ажиллах хүч	6
9.4.2 Ажилгүйдэл	8
9.4.3 Эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд	9
9.4.4 Хөдөө аж ахуй	9
9.4.5 Уул уурхайн салбар	10
9.4.6 Бусад салбар	12
9.4.7 Орлого	12
9.5 ӨМНӨГОВЬ АЙМАГ	12
9.5.1 Нийт ажиллах хүч	12
9.5.2 Ажилгүйдэл ба тогтвортой бус хөдөлмөр эрхлэлт	12
9.5.3 Эдийн засгийн салбар	13
9.5.4 Мал аж ахуйн үйлдвэрлэл	13
9.5.5 Газар тариалан	13
9.5.6 Уул уурхай	14
9.5.7 Жижиг дунд бизнес	15
9.5.8 Ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн оролцоо	15
9.5.9 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт	16
9.5.10 Хүүхдийн хөдөлмөр	16
9.5.11 Орлого ба зарлага	16
9.5.12 Орлогыг дэмжих нь	18
9.6 ХАНБОГД СУМ	20
9.6.1 Нийт ажиллах хүч	20
9.6.2 Ажилгүйдэл	20
9.6.3 Эдийн засгийн салбар	20
9.6.4 Мал аж ахуйн үйлдвэрлэл, нүүдлийн мал аж ахуй	21
9.6.5 Газар тариалан	23
9.6.6 Жижиг бизнес	23
9.6.7 Төрийн албан хаагч	26
9.6.8 Уул уурхайн салбар	27
9.6.9 Орлого ба зарлага	27
9.6.10 Нэмэлт орлого	28
9.6.11 Эдийн засгийн эмзэг бүлэг	29
9.7 ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖЛУУД	29

Зургийн жагсаалт

Зураг 9.1: Монгол улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин, 2003-2010	8
Зураг 9.2: Оюу Толгойн төсөлд хүнсний ногоо нийлүүлдэг Даланзадгад сумын ХАА-н хоршоолол	14
Зураг 9.3: Ханбогд сумын хөдөлмөр эрхлэлтийг эдийн засгийн салбар тус бүрээр нь харуулсан байдал, 2007	21

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 9.1: ОУХБ-ын үндсэн конвенцэд нэгдэн орсон нь	6
---	---

Хүснэгт 9.2: Хөдөлмөр эрхлэлт үндэсний хэмжээнд ба говийн аймгуудад (2010).....	7
Хүснэгт 9.3: Үндэсний хэмжээнд хүн амын ажиллах хүчний нөхцөл байдал (15 жил +)	7
Хүснэгт 9.4: Хөдөлмөр эрхлэлт эдийн засгийн салбар бүрээр	9
Хүснэгт 9.5: Говийн аймгуудад хэрэгжих томоохон хэмжээний уул уурхайн төслүүд	10
Хүснэгт 9.6: Оюу Толгой ХХК болон гэрээт компаниудын ажилтнуудын тоо, 2011 оны 2-р сарын байдлаар.....	11
Хүснэгт 9.7: Оюу Толгой төслийн ажилчдын тоо, оршин суудаг харъяалалаар, 2010 оны 12-р сар	14
Хүснэгт 9.8: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн сарын дундаж орлогын бүтэц /%/	16
Хүснэгт 9.9: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн сарын нийт орлого бэлэн мөнгөөр	17
Хүснэгт 9.10: Сарын дундаж орлого /эрхэлж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбараар/	17
Хүснэгт 9.11: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн нэг хүнд ноогдох сарын зарлага	18
Хүснэгт 9.12: Айл өрхүүдийн санхүүгийн тусламж дэмжлэг авдаг газрууд %	19
Хүснэгт 9.13: Ханбогд сумын малчдын ахуй амьжиргааны гол тоо баримтууд, 2011	22
Хүснэгт 9.14: Бүртгэлтэй жижиг бизнесийн байгууллагууд ба ажиллагсдын тоо, 2010.....	23
Хүснэгт 9.15: Ханбогд сумын хувиараа бизнес эрхлэгчид ба тэдгээрийн үйл ажиллагаа, 2010 оны 3-р сар.....	26
Хүснэгт 9.16: Ханбогд сумын төвөөс гадна байрладаг дэлгүүр, бизнесүүд, 2011	26
Хүснэгт 9.17: Ханбогд сумын төрийн байгууллагууд ба ажилтнууд, 2009, 2010 он.....	26
Хүснэгт 9.18: Ханбогд сумын өрхийн орлогын задаргаа (сараар), 2008.....	28
Хүснэгт 9.19: Зээлийн зориулалт, судалгаанд оролцогсдын %, 2008.....	28
Хүснэгт 9.20: Зээлдүүлэгчдийн төрөл, судалгаанд оролцогсдын %, 2008	29

9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА АМЬЖИРГААНЫ ТҮВШИН

9.1 ТАНИЛЦУУЛГА

Тайлангийн энэхүү бүлэгт Оюу Толгой төслийн хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүч, ажлын байрны орчин нөхцөлтэй холбоотой асуудлыг үндэсний, аймгийн болон сумын хэмжээнд авч үзэх болно. Оюу Толгой төсөл хэрэгжих Ханбогд сум нь нүүдлийн болон хагас нүүдлийн шинж чанартай мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл голчлон эрхэлдэг хүн ам бүхий газар хэдий ч сумын төвийн иргэд нь жижиг хэмжээний худалдаа, үйлчилгээ, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх нь улам бүр нэмэгдэж байна.

9.2 АРГА ЗҮЙ

Анхан шатны мэдээллийн эх сурвалж

Төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэлт болон амьжиргааны түвшингийн суурь судалгааг хийх зорилгоор хэд хэдэн эх сурвалжийг ашигласан билээ. Ялангуяа энэхүү төсөлд зориулан боловсруулсан мэдээлэл нь дараах судалгаа, шинжилгээг багтааж байна. Үүнд:

- *2008 оны Өмнөговь аймгийн Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны суурь судалгаа.* Оюу Толгойн захиалгаар Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төвтэй хамтран энэхүү судалгааг явуулсан. Төсөл хэрэгжих бүсийн зэргэлдээ орших сумдын талаарх илүү нарийвчилсан дэлгэрэнгүй судалгааг ижил мэдээлэл, баримт, материал дээр үндэслэн 2009 онд хийсэн бөгөөд уг тайланг *Оюу Толгой төслийн Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны дэд судалгаа* нэртэйгээр боловсруулан гаргасан. Үндсэн судалгааны гол чиглэл нь Өмнөговь аймаг байсан бөгөөд дэд тайлангийн гол судлагдахуун нь Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогтцэций болон Даланзадгад сумдууд байсан ба Өмнөговь аймгийн мэдээллийг харьцуулах үүднээс оруулж өгсөн байна. Судалгаанд тус аймгийн нийт айл өрхийн 10%-тай тэнцэхүйц 1,323 айл өрх хамрагдсаны 70 нь Ханбогд сумын төвийн, 37 нь сумын хөдөө орон нутгийн айл өрх байсан. Энэ бүлэгт ажиллах хүчний тоо, ажилтай болон ажилгүй иргэдийн тоо /нас ба хүйсээр нь/, орлогын хуваарилалт, хөдөлмөр эрхлэлтийн салбарууд, ажиллах орчин нөхцөл, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн талаарх мэдээлэл, тоо баримтуудыг энэ бүлэгт авч үзсэн.
- *2009 оны Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ.* Оюу Толгой нь нийт 5 сумын 141 иргэн, 29 албан хаагч, 32 бусад иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчдийг судалгаандаа хамруулсан (Бүлэг А6: *Олон нийтийн хэлэлцүүлэг*). Судалгааг Бодлого судлалын төв болон Хүн амын сургалт, судалгааны төвүүд хамтран явуулж, хөдөлмөр эрхлэлтийн голлох үзүүлэлтүүд болон орлогын эх үүсвэрт үнэлгээ хийж, төслийн нөлөөллийн бүс дэх бизнесийн хэмжээ, бүтэц, харьцаа зэрэгт дүн шинжилгээ хийсэн юм.
- *(2010 -2011) Нөлөөлөлд өртсөн байж болзошгүй малчин өрхүүдийн судалгаа.* Энэ судалгааг Оюу Толгой нь 2010 оны 9-р сараас 2011 оны 5-р сар хүртэлх хугацаанд явуулсан бөгөөд нийт нөлөөлөлд өртсөн айл өрхүүд болон Ханбогд сумын малчин өрхүүдээр зочлон нарийвчилсан судалгаа хийсэн байна. Судалгаанд 84 айл өрх оролцсон бөгөөд өрхийн гишүүдийн бүтэц, ажил эрхлэлт болон орлогын эх үүсвэр, малын тоо толгой болон бусад хөрөнгө, зардлын тооцоо зэргийг тодорхойлсон.

Хоёрдогч (бэлэн) мэдээллийн эх сурвалж

Хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээ, хөдөө аж ахуй (ХАА)-н болон мал аж ахуйн үзүүлэлтүүд, эд баялгийн үзүүлэлтүүд, үйлдвэр аж ахуй газруудын жагсаалт, Ханбогд сумын бизнесүүд болон орлогыг дэмжих арга хэмжээ зэрэг мэдээ, мэдээллийг Өмнөговь аймгийн Статистикийн газар, аймаг ба сумын Засаг даргын тамгын газраас тус тус авсан. Энэхүү цуглуулсан мэдээ, мэдээллийг Оюу Толгой нь өөрийн мэдээллийн сандаа оруулсан бөгөөд уг мэдээллийн сандаа байнгын шинэчлэлт хийдэг. Тайланд мөн Н.Аюушийн “Монгол улсын ажлын байрны аюулгүй ажиллагаа ба эрүүл мэндийн үзүүлэлт”, 2006 оны Банкок хот, “Олон улсын хөдөлмөрийн байгууллага”, тайлан байна. Үүнээс гадна мэдээллүүдийг цуглуулахад өөр бусад хоёрдогч эх сурвалжуудыг ашигласан бөгөөд тухайлбал, Монголын үндэсний статистикийн газар болон Дэлхийн банкны материалууд ба эх сурвалжуудыг холбогдох хэсэгт нь дурдсан болно.

9.3 ХӨДӨЛМӨР БА АЖЛЫН БАЙРНЫ ОРЧИН НӨХЦӨЛ

9.3.1 Монгол улсын стандарт

Хууль эрх зүйн орчин

Монгол улс нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжиж ороод удаагүй байгаа бөгөөд өмчийг хувьчилснаар хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах, хянах механизмуудыг шинэчлэн чөлөөт зах зээлийн зарчимд нийцүүлэх шаардлагатай болсон. 1991 онд БНМАУ-ын хөдөлмөр эрхлэлтэд тавих шаардлага шинээр батлагдсан бөгөөд энэхүү шаардлагын дагуу Ажлын байрны аюулгүй ажиллагааг хангах журмуудыг Засгийн газар (ЗГ) харин бусад дүрэм, журмууд болоод хөдөлмөр эрхлэлтийн стандартуудыг бусад түвшний төр захиргааны төв байгууллагууд болон яамд батлах ёстой хэмээн заасан байдаг.

Эдгээр дүрэм журам, стандартуудыг урьд нь зөвхөн Монголын үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөл, түүний салбар нэгжийн зөвлөмж саналын дагуу боловсруулан батлуулдаг байсан юм. Энэхүү хуулинд заасан ажил олгогч нь ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн нөхцлийг хангах үүрэгтэй гэдэг заалтыг хэвээр үлдээж, үйлдвэрлэлийн осол аваар болон мэргэжлийн өвчинд өртсөн ажилтанд олгох нөхөн төлбөрийн журмыг өөрчлөн шинэчилсэн байна.

Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийг 1999 оны 7 –р сарын 01-нд шинээр баталснаар Монгол улсын ажил олгогч байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг бий болгох шаардлагатай болсон юм. Энэ шинэ хуулийн зорилго нь ажил олгогч, ажилтан нарын эрх үүрэг, хариуцлагыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хамтын болон бие даасан журмаар хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх, ажлын байрны нөхцөл шаардлага, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд ноогдуулах хариуцлага, хүйсийн эрх тэгш байдлыг хангах зэргийг тогтоож өгөхөд чиглэгдсэн.

Энэхүү шинэ хуулинд ажилтан нь аюулгүй, эрүүл мэндийн шаардлага хангасан ажлын байранд ажиллах, ажилласны хөлс цалин авах, амрах, өөрийн эрх ашгийг хамгаалахын тулд бусад ажилтнуудтай эвлэлдэн нэгдэх, төлөөлөгчдийн байгууллага болон хамтын гэрээгээр дамжуулан хуулийн дагуу эрх ашгаа хамгаалуулах, тодорхой нөхцөлд ажил хаях, тэтгэвэр тэтгэмж авах, нийгмийн даатгалд хамрагдах, ажил үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдвал нөхөн олговор авах болон хөдөлмөрийн, хамтын гэрээнд заагдсан бусад нөхцлийг эдлэх эрхтэй байна гэж заажээ.

Ажлын байран дээр ажилтныг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахыг хатуу хориглоно. Гэхдээ тусгай журамд заасны дагуу эмэгтэйчүүд зарим тодорхой төрлийн ажил эрхлэхийг хориглосон байдаг. Хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг хориглосон ба жирэмсний амралтыг эдлэнэ. 3-аас доош насны хүүхэдтэй эцэг эхэд хүүхэд асрах чөлөө олгох ба тэр хугацаанд ажил олгогч ажлын байрыг хэвээр хадгалах үүрэгтэй.

Хамтын гэрээг бүс нутгийн, аймаг, сум, дүүргийн хэмжээнд мэргэжлээр эсвэл эдийн засгийн үйл ажиллагааны салбарт байгуулж болно. Хамтын гэрээг байгуулсан тухай мэдэгдлийг холбогдох бүртгэлийн газрууд бүртгэж авна. Хөдөлмөрийн арбитрын шүүх нь эвлэлдэн нэгдсэн хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх бол хөдөлмөрийн комисс нь хувь иргэдтэй холбоотой хөдөлмөрийн маргааныг шүүн шийдвэрлэнэ.

Хөдөлмөрийн харилцаа

Хөдөлмөрийн харилцаатай холбоотой зохицуулалтуудыг Монгол улсын эрх зүйн шинэчлэлийг хүрээнд хэрэгжүүлсэн. Шинэ нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн Хөдөлмөрийн хуулинд 1991 болон 1999 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан ба Үйлдвэрчний Эвлэлийн Тухай хуулийг шинээр баталснаар нийгмийн гурван талт харилцааг зөв зохистой хөгжүүлэхэд чухал алхам болсон билээ. Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо (МҮЭНХ) нь 450,000 гаруй гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн үндэсний хэмжээний томоохон байгууллага юм. МҮЭНХ нь ажил олгогч болон Засгийн газартай хөдөлмөрийн харилцаанд орж буй хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг.

Эдгээрээс гадна 1998 онд Монгол улс нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Олон улсын хөдөлмөрийн стандартын хэрэгжилтийг дэмжих зорилго бүхий гурван талт хэлэлцүүлгийн тухай 144-р конвенцид нэгдэн орсон. Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн 138-р хэсэгт хөдөлмөр ба нийгмийн харилцааны Гурван талт Зөвлөлийг үндэсний хэмжээнд байгуулна гэж заасан ба Зөвлөлийн бүрэлдэхүүн нь Засгийн газар, ажил олгогч болон ажилтны төлөөллөөс тус тус бүрдэнэ.

Энэ зөвлөл нь нийгмийн хэмжээний яриа хэлэлцээрүүдийг зохицуулах үндэсний хэмжээний хамгийн том механизм байх юм.

Хөдөлмөр эрхлэлтийн боломжийг ижил тэгш олгох сонирхлын үүднээс Оюу Тодгой нь Засгийн газартай хамтран эмэгтэйчүүдийг уул уурхайн салбарт тодорхой ажил хөдөлмөр эрхлэхийг нь хориглосон дүрэм журмуудыг чөлөөлөх боломжуудыг эрэлхийлсээр байна (тухайлбал 2,5 тоннийн даацаас дээш авто тээвэр жолоодох, уурхайн гүнд ажиллах мөн уурхайн аврах ангид ажиллах зэрэг орно). Энэхүү асуудлаар Оюу Толгой нь Монголын засгийн газартай нягт хамтран ажиллаж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийг уул уурхайн салбартай холбоотой бүхий л чиглэлийн ажилд амжилттай шилжүүлж чадсан Австрали, Канад, АНУ зэрэг орнуудын туршлагаадаас жишээ болгон цуглуулсаар байна. Монгол улсын боломжит ажиллах хүчний 50%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг учир энэ санаачлага нь тус компаний хүний нөөц болон сургалтын стратегийн гол бүрэлдэхүүн хэсэг байх болно.

Хөдөлмөрийн насны доод хязгаартай холбоотой хууль тогтоомж

Монгол улсын Хөдөлмөрийн Хуулийн 109-р зүйлд зааснаар, хөдөлмөр эрхлэлтийн насны доод хязгаар нь 16 нас байх ба 15 настай хүүхэд хөдөлмөр эрхлэх тохиолдолд асран хамгаалагч/эцэг эхийн зөвшөөрөл авна харин 14 настай хүүхэд мэргэжлийн боловсрол сургалт буюу ажилд асран хамгаалагч/эцэг эх болон засгийн газрын зөвшөөрөлтэйгээр хамрагдахыг зөвшөөрсөн байдаг. Хөдөлмөрийн хуулиар 18-аас доош насны хүүхэд илүү цагаар, амралтын болон баярын өдрүүдэд ажиллахыг хориглодог мөн хүүхдийн наснаас хамааран хууль ёсны хөдөлмөр эрхлэх цагийг хязгаарласан байдаг. Тиймээс Оюу Толгой төсөл нь хөдөлмөр эрхлэлтийн бодлогодоо ажилтан авах насны доод хязгаарыг 18 гэж заасан ба Оюу Толгойн гэрээт гүйцэтгэгч нар мөн энэхүү бодлогыг дагаж мөрдөнө.

9.3.2 Олон улсын стандарт, конвенциуд

Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн Гүйцэтгэлийн стандарт (2006 он) болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны гүйцэтгэлийн шаардлага (2008)

ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 2, ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 2 зэрэгт хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны нөхцлийн талаар тодорхой шаардлагуудыг зааж өгсөн байдаг ба хоорондоо ижил төстэй бөгөөд гол шаардлагууд нь:

- *Байгууллагын хэмжээ болоод ажиллах хүчиндээ тохирсон хүний нөөцийн бодлоготой байх ба энэ нь ажилчдыг зохион байгуулах арга барилыг тусгасан байна. Мөн ажилчдыг зохион байгуулах эерэг харилцааг бий болгох болон хадгалах.*
- *Ажилтны цалин хөлс, урамшуулалтай холбоотой эрх оруулан хөдөлмөр эрхлэгчдийн эрхийн талаарх хууль тогтоомж, журмын мэдээллээр хангах. Бодлого журмыг бүгдэд ойлгомжтой, тодорхой байдлаар боловсруулан тайлбарлаж таниулах, шинээр хөдөлмөр эрхлэгч бүрт нээлттэй байлгах;*
- *Бүх ажилтан ажиллагсадтай ажлын байрны нөхцөл, цалин хөлс, бусад тэтгэмж тусалцааны талаар шууд байдлаар холбогдон хэлэлцэх ба баримтжуулах;*
- *Улс оронд мөрдөгдөх хууль тогтоомжийн хүрээнд ажилтнууд эвлэлдэн нэгдэх, мэргэжлийн байгууллагуудад гишүүнээр элсэхийг зөвшөөрөх, ажилтнуудын хамтран эвлэлдсэн байгууллага байгуулах буюу элсэн ороход саад тавихгүй байх, ийм байгууллага байгуулах, элсэх хүсэлтэй ажилчдыг ялгаварлан гадуурхахгүй байх;*
- *Тухайн улсын хуулинд ажилтнуудыг ялгаварлан гадуурхахгүй байхтай холбоотой хууль журам заагдсан байдаг бол түүнийг дагах, ажилтнуудтай шударгаар хандах, ялгаварлахгүй байх, боломж нөхцлийг ижил тэнцүү хангах зэргийг дэмжиж, хөдөлмөрийн харилцаагаа энэ зарчим дээр тулгуурлан бий болгох. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ажилтныг ажилд авах, нөхөн олговор олгох, ажлын нөхцлөөр хангах, дэмжлэг тусалцаа үзүүлэх, сургалтад хамруулах, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, тэтгэвэрт гарах зэрэг харилцаанд ялгаварлан гадуурхах үзлийг гаргахгүй байх;*
- *Ажлын байрыг ихээхэн хэмжээгээр татан буулгах, ажилтнуудын тоог цөөрүүлж ажлын байрны цомхотгол хийх тохиолдолд сөрөг нөлөөллийг сааруулах төлөвлөгөөг боловсруулах;*

- *Ажлын байрны нөхцлийг сайжруулах үүднээс ажилчдын санал хүсэлт, гомдол барагдуулах механизмыг бий болгох мөн шинээр ажилд орох үед ажилчдадуг гомдол барагдуулах механизмыг танилцуулж, ажлын байртай холбоотой санал хүсэлтийг цаг тухайд нь саадгүй мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх;*
- *Эрүүл, аюулгүй ажлын байраар хангах замаар ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах болондэмжих;*
- *Эдийн засгийн ашиг олох зорилгоор хүүхдийн хөдөлмөрийг мөлжихгүй эсвэл хортой байж болох нөхцөлд ажиллуулахгүй байх, эсвэл хүүхдийн боловсролд саад болохоор, эсвэл хүүхдийн эрүүл мэнд мөн биеийн хөгжил, оюун ухаан, зан төлөв болон нийгэмшихэд нь саад болох хортой хөдөлмөрт ажиллуулахгүй байх, 18-аас доош насны хүүхдийг аюул, эрсдэлтэй ажлын байран дээр ажиллуулахыг хориглох;*
- *Ямар нэгэн ажил үйлчилгээг хүчээр бус сайн дурын үндсэн дээр явуулах, айлган сүрдүүлэх арга барил хэрэглэхийг хориглох.*

Олон улсын хөдөлмөрийн конвенц

Монгол улс нь Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын *Ажлын байрын аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн 155-р конвенцид* 1999 онд элсэн орсон. Конвенцийн заалтад нийцүүлэн хууль эрх зүйн орчны шинэчлэл хийсэн ба энэ ажлын¹ хүрээнд ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудалтай холбоотой хууль тогтоомж, журмуудыг шинэчлэн боловсруулж байна. Монгол улсад энэ талын хууль тогтоомж байгаа хэдий ч стандартууд нь олон улсын түвшиний шаардлагыг хангаж чаддаггүй. Ялангуяа, үйлдвэрлэлийн осол аваар, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар ойлголт мэдлэг өгөх ажлууд орхигдсон байдаг.

Хүснэгт 9.1-т харуулсан ОУХБ-ын 8-н конвенцид Монгол улс нэгдэн ороод байгаа ба эдгээр нь ажлын байранд хүний эрхийг хамгаалах үндсэн тулгуур болдог байна.

Хүснэгт 9.1: ОУХБ-ын үндсэн конвенцэд нэгдэн орсон нь

ОУХБ-н конвенцийн дугаар, нэр, он	Соёрхон Баталсан Огноо
29 “Албадан хөдөлмөр эрхлүүлэх” (1930)	15/03/2005
87 “Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах” (1948)	03/06/1969
98 “Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай конвенц” (1949)	03/06/1969
100 “Эрх тэгш цалин хөлс” (1951)	03/06/1969
105 “Албадан хөдөлмөр эрхлүүлэлтийг халах” (1957)	15/03/2005
111 “Алагчилахгүй байх /ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/” 1958	03/06/1969
138 “Хөдөлмөрийн насны доод хязгаар” (1973)	16/12/2002
182 “Хүүхдийн хүнд хүчир хөдөлмөрийг таслан зогсоох” (1999)	26/02/2001

Эх сурвалж: *Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)*

9.4 ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

9.4.1 Нийт ажиллах хүч

Эдийн засгийн идэвхитэй хүн ам гэдгийг Монгол улсын Үндэсний Статистикийн байгууллагаас доорх байдлаар тодорхойлсон :

“...ОУХБ-аас гаргасан шаардлагын дагуу Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн хэлтэст бүртгэлтэй ажилтай болон ажилгүй бүх иргэдийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн хэлтэст бүртгэлгүй ажилгүй иргэд, армид алба хааж буй иргэд, шоронд хоригдогсад, сурагчид болон 16 буюу түүнээс дээш насны оюутнууд зэрэг нь эдийн засгийн идэвхитэй хүн амд

¹Аюуш Ням , Үндэсний хэмжээний ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн лавлах, Банкок хот, ОУХБ , 2006 он.

багтахгүй. Эдийн засгийн идэвхитэй гэдэг нь жил буюу түүнээс дээш хөдөлмөр эрхэлсэн иргэдийг оруулан ойлгодог.”

Тиймээс газартай холбоотой хөдөлмөр эрхэлдэг малчин, газар тариаланч зэрэг хүмүүсийг ажиллах хүчний статистикт багтаадаг. Ажилтай хүн гэж ...“(а) ажил хийж орлого олдог иргэд, гэр бүлийн бизнест цалингүй ажил эрхэлдэг хүмүүс, (б) эдийн засгийн бус шалтгаанаар ажил эрхлээгүй эсвэл өвчин, цаг агаарын нөхцөл, ээлжийн амралт зэргээс шалтгаалан түр хугацаагаар ажлаасаа чөлөөлөгдсөн ажилтан.”-г хэлнэ.

Манай улсын эдийн засгийн идэвхитэй хүн ам нь 2010 онд 1.137 сая байсан ба ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ)² 66.8%-тай тэнцүү байв (Хүснэгт 9.2). Үндэсний хэмжээнд АХОТ нь 2004 оноос хойш 64.0%-аас 66.8%-ийн хэлбэлзэж байна. Эмэгтэйчүүдийн АХОТ нь үндэсний түвшинтэй бараг ижил буюу 63.2% байсан ба бүртгэлтэй ажилгүйчүүдийн эзлэх хувь нь мөн үндэсний хувьтай /3.2%/ адил байна. 2009 оны 3-р улирлаас 2010³ оны 3-р улирал хүртэлх хугацаанд нийт ажиллагсдын тоо даруй 71.5 мянгаар өсчээ. Харин 2002 оноос 2009 он хүртэлх хүйс, хөдөө болон хотоор нь ангилсан бусад гол хөдөлмөр эрхлэлтийн байдлыг Хүснэгт 9.3 дугаар хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 9.2: Хөдөлмөр эрхлэлт үндэсний хэмжээнд ба говийн аймгуудад (2010)

Аймаг	Эдийн засгийн идэвхитэй хүн ам, '000	Ажил эрхэлдэг, '000	Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь	Ажиллах хүчний оролцооны түвшин, %	Хөдөлмөр эрхлэлт, %	Бүртгэлтэй ажилгүйчүүдийн эзлэх хувь, %
Үндэсний дундаж	1 137.9	1 006.3	62.3	66.8	88.4	3.3
Говь-Сүмбэр	6.1	4.8	67.7	67.7	78.9	2.6
Дорноговь	25.3	20.1	63.6	68.3	79.5	2.1
Дундговь	24.1	20.9	63.7	79.3	86.7	2.3
Өмнөговь	27.3	23.2	68.8	80.5	84.9	1.8

Эх сурвалж: 2010 оны Статистикийн лавлах, Үндэсний Статистикийн Газар

Хүснэгт 9.3: Үндэсний хэмжээнд хүн амын ажиллах хүчний нөхцөл байдал (15 жил +)

Үзүүлэлт	2002 - 2003	2006 – 2007	2009
Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ('000)	862.5	898.9	977.4
Эр	448.9	435.1	516.5
Эм	413.6	463.8	460.9
Хотын	392.3	442.5	524.3
Хөдөөний	470.2	456.4	453.1
Хөдөлмөр эрхлэлтийн байдал ('000)	-	-	-
Цалинтай ажил эрхлэгч	338.6	336.8	395.2
Ажил олгогч	5.5	6.0	21.3

² Ажиллах Хүчний Оролцооны Түвшин гэдэг нь 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхитэй хүн амд эзлэх хувь хэмжээ.

³ Үндэсний эдийн засгийн дүн шинжилгээ, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, Монгол улс, 2010 он.

Үзүүлэлт	2002 - 2003	2006 – 2007	2009
Хувиараа ажил эрхлэгч	303.4	306.4	226.4
Гэрийн ажил	215.0	249.7	99.5
Хоёрдогч ажлын байр ('000)	23.9	18.0	n/a*
Эр	14.6	11.2	n/a
Эм	9.3	6.8	n/a
Тогтвортой бус ажил эрхэлдэг ('000)	58.2	41.1	n/a
Эр	34.4	18.6	n/a
Эм	23.8	22.5	n/a

* энэ хэвлэлд байхгүй байсан


Эх сурвалж: Статистикийн лавлах 2008, 2010 оны сар бүрийн статистикийн журнал, Үндэсний Статистикийн Газар. Жич: эдгээр мэдээг аймаг аймгаар ангилаагүй болно.

9.4.2 Ажилгүйдэл

Үндэсний статистикийн лавлах 2010-аас харахад үндэсний хэмжээнд ажилгүйдлийн түвшин сүүлийн таван жилийн туршид тогтмол 3.3% орчимд байсан байна. (Зураг 9.1-г харна уу) 2010⁴ оны хоёрдугаар хагасаас хойш бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 40,000 орчимд тогтвортой байна. Гэхдээ энд зөвхөн нийслэл хот, аймаг, сумдын хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэгдсэн ажилгүй иргэдийн тоог багтаасан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

2010 оны 3-р улирлын ажиллах хүчний судалгаагаар⁵, албан ёсны бүртгэлгүй иргэдийг ажилгүй гэж тооцож үзэхэд ажилгүйдлийн түвшин 8.6% байгаа ба үүний 10.5% нь хот суурин газарт, 6.5% нь хөдөө орон нутагт оногдож байна. Энэ түвшин нь 2009 оны 09 сарынхаас 10.5%-аар буурчээ. Энэ нь нийт 1,193,000 ажиллах хүчний 103,000 хүн нь ажилгүй байна гэсэн үг юм.

Зураг 9.1: Монгол улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин, 2003-2010



Эх сурвалж: CIA⁶, Статистикийн лавлах, 2010.

⁴ Монгол улсын эдийн засгийн улирлын мэдээ, ДБ, 2011.01 сар

⁵ ОУХБ-ын аргачлалаар ҮСГ-аас “Ажиллах хүчний судалгаа”- г 2007 оноос эхлэн улирал бүр явуулж байна.

⁶ АНУ-ын Тагнуулын Төв газар, Дэлхийн тоо баримт 2010 он.

http://www.indexmundi.com/mongolia/unemployment_rate.html

9.4.3 Эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд

ХАА ба мал аж ахуйн салбар нь Монгол улсын эдийн засгийн үйл ажиллагааны гуравны нэг хувийг нь эзэлдэг. 2009 онд үндэсний хэмжээнд хүн амын 34%⁷ нь мал аж ахуйгаас хамааралтайгаар амьжиргаагаа залгаж байсан ба хөдөөгийн айл өрхийн 63%-ийнх нь эд хөрөнгөд мал сүрэг⁸ багтаж байсан байна. 2006-2007 онуудад Үндэсний Статистикийн Газраас үндэсний хэмжээнд болон Өмнөговь аймагт явуулсан *Ажиллах хүчний судалгаанд* хамгийн сүүлийн үеийн эдийн засгийн үйл ажиллагаануудыг салбар бүрээр нь гаргасан мэдээллүүд тусгагдсан бөгөөд үр дүнг Хүснэгт 9.4-т харуулсан байна.

Хүснэгт 9.4: Хөдөлмөр эрхлэлт эдийн засгийн салбар бүрээр

Салбар (% ажил эрхлэлт)	Үндэсний хэмжээнд нийт	Говь-Сүмбэр	Дорноговь	Дундговь	Өмнөговь
Ажил эрхэлж буй нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, агнуур	38.4	10.5	40.3	71.2	63.1
Уул уурхай	4.2	13.8	1.6	1.0	4.2
Боловсруулах үйлдвэрлэл	4.6	1.2	0.6	0.5	0.3
Эрчим хүч, халаалт болон усан хангамж	3.1	16.2	1.9	0.8	1.6
Барилга	5.6	2.8	6.1	0.5	0.5
Бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн бараа бүтээгдэхүүн	15.8	6.3	10.3	8.2	8.9
Зочид буудал, ресторан	3.1	2.4	1.2	0.8	0.7
Тээвэр, агуулах, харилцаа холбоо	4.1	9.0	11.7	1.8	2.3
Санхүү	1.7	4.4	1.3	1.0	0.8
Үл хөдлөх хөрөнгийн зээл, түрээс болон бизнес	1.2	2.5	3.6	0.5	1.8
Төр захиргаа, батлан хамгаалах, даатгал	4.7	7.6	10.4	5.5	8.2
Боловсрол	6.1	7.6	5.8	4.9	4.7
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбар	3.9	6.7	3.5	2.7	2.2
Олон нийтийн салбар	2.3	7.3	1.7	0.4	0.4
Фермерийн бус аж ахуй	0.7	0.9	0.1	0.0	0.3
Тусламжийн байгууллага	0.4	0.7	0.0	0.2	0.1

Эх сурвалж: *Статистикийн газрын мэдээ, 2010 (2006-2007 оны судалгаа), Говийн бүсийн Техник мэргэжлийн үр чадвар, хөдөлмөр, сургалт судалгааны эцсийн тайланд дурдсан, 2010.10.29. Sustainability Зүүн Ази, ХХК.*

9.4.4 Хөдөө аж ахуй

Нүүдлийн мал аж ахуй бол Монгол орны эдийн засагт онцгой байр суурь эзлэдэг салбар бөгөөд хөдөө орон нутгийн хүн амын амьжиргааны гол үндэс нь болдог. ХАА-н салбар нь ажиллах хүч болон эдийн засгийн гол тулгуур хэвээр байгаа ч ач холбогдол нь улам бүр буурсаар байна. 2009 оны эцсээр ХАА-н нийт бүтээгдхүүний 86%-ийг мал аж ахуй эзлэж байсан бол 2005⁹ онд энэ нь 92%-тай байв. Дотоодын нийт бүтээгдэхүүнд ХАА-н салбарын эзлэх хувь нь 1995 онд 33% тай байсан бол 2009¹⁰ онд 23% болон буурчээ. ХАА-н салбарын ажиллах хүчний тоо 2009 оны 3-р

⁷ 2008 он. АНУ ын Тагнуулын Төв газар, Дэлхийн тоо баримт : Монгол улс URL: www.cia.gov.

⁸ <http://blogs.worldbank.org/eastasiapacific/dzud-a-slow-natural-disaster-kills-livestock-and-livelihoods-in-mongolia>

⁹ “Оюутолгой зэсийн уурхай: Монгол улсын макро эдийн засгийн судалгаа”, МУИС ийн Эдийн засгийн сургууль, 2011 он.

¹⁰ Эдийн засгийн сургууль, 2011 он.

улирлаас 2010 оны 3-р улирлын хооронд 46.9 мянган хүнээр нэмэгдсэн байна. 2009 -2010¹¹ онуудад нийт ажиллах хүчний тоонд ХАА-н салбарт ажиллагсдын эзлэх хувь 2%-аар ахисан дүнтэй байна. Энэ нь 2005- 2008 оны хооронд ХАА-н салбарт ажиллагсдын тоо тогтмол буурч ирсэнтэй харьцуулахад томоохон өөрчлөлт юм. /40%, 39%, 38% 36% болон буурч байв/.

2006 онд 36 сая толгой мал тоологдсон бол 2008 онд 37 сая толгой мал тоологдсон байна. 2010 оны малын тооллогоор энэ тоог 40 сая толгойд хүрэх болно гэж тооцоолжээ. /Хамгийн сүүлийн тооллогын дүн 2011 оны 7 сард гарна/.

Мал сүргийн өсч буй тоо толгойнд ямаа, үхэр, адуун сүргийн тоо илүү нэмэгдэж байгаа бол тэмээн сүргийн тоо толгой хорогдож байна.

Газар тариалангийн нэг га талбайгаас авах ургацын хэмжээ нэн ялангуяа улаан буудайн тариалангийн хувьд бага хэвээр байгаа бөгөөд 2004 - 2007 онуудад улсын хэмжээнд 116.9 мянган тонн улаан буудай хураан авсан нь 2000 – 2003 оны хооронд хураан авсан улаан буудайн хэмжээнээс 26.9 мянган тонноор бага байна. Тиймээс өнөөдрийг хүртэл Монгол улс хүнсний импортын бараанаас хамааралтай орон хэвээр байгаа юм.¹² Улаан буудайн ургацын хэмжээ буурсан хэдий ч төмс хүнсний ногооны ургацын хэмжээ нэмэгджээ. Монгол улсад хүнсний аюулгүй байдал нь тулгамдсан асуудал болоод байгаа бөгөөд гол хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь жилээс жилд өөр өөр хэмжээтэй байдаг тул хүнсний бүтээгдэхүүнээ импортоор авах шаардлага тулгардаг байна (гол төлөв Орос болон Хятад улсаас).

9.4.5 Уул уурхайн салбар

Монгол улс нь зэс, цайр, алт, нүүрс зэрэг ашигт малтмал, эрдэсээр баялаг бөгөөд уул уурхай нь аж үйлдвэрийн боловсруулалтын салбарт томоохон байр суурь эзлэх болсон. 2009 онд уул уурхай, олборлолтын салбар нь ДНБ-ний 28%-ийг, экспортын орлогын 86.1%-ийг тус тус эзлэж байв. 2008 онд ДНБ-д эзлэх хувь нь 27% байсан байна. Дэлхийн зах зээлд ашигт малтмалын үнэ өсч байгаа нь олон улсын зүгээс Монголын эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулагчдыг ихээхэн татах болсон.

Таван жилийн дараа гэхэд Өмнийн говийн уул уурхайнуудад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 5 тэрбум ам.долларт хүрнэ гэж тооцоолжээ. Ашигт малтмалын хайгуулын ажлуудын үр дүнд уул уурхайн ашиглалт олборлолтын шинэ шинэ төслүүд тус орны эдийн засгийн төв бүс ялангуяа өмнийн говийн аймгуудад хэрэгжихээр төлөвлөгдөж байна. Састайнабилити Ийст Азия ХХК нь 2010 онд *Техник, мэргэжлийн үр чадвар, ажиллах хүч ба сургалт* нэртэй судалгааг хийж, Өмнийн говийн бүст ирэх таван жилийн хугацаанд хэрэгжих томоохон хэмжээний уул уурхайн төслүүдийн хүрээнд нэмэгдэх ажлын байрны тоог тооцоолжээ (Хүснэгт 9.5). Уул уурхайн салбарт өсөн нэмэгдэж буй ажлын байрны эрэлт хэрэгцээний улмаас уул уурхайн компаниудын дунд мэргэшсэн болон мэргэшээгүй ажилчдын төлөөх өрсөлдөөн нэмэгдэх хандлагатай бөгөөд тухайн салбарын мэргэжилтэнүүдэд боломж олгогдож байгаа тул компаний сургалтанд суух нь чухал болсон. Ажиллах хүчний өрсөлдөөн ихээр нэмэгдэх нь зайлшгүй тул уул уурхайн салбарын ажиллах хүчинд үзүүлэх эерэг нөлөөлөл нь үндэсний хэмжээнд байх хандлагатай юм..

Хүснэгт 9.5: Говийн аймгуудад хэрэгжих томоохон хэмжээний уул уурхайн төслүүд

Ордын нэр	Ашигт малтмал	Ашиглах хугацаа	Олборлолтын хэмжээ, ('000 тонн/жилд)	Шинээр бий болгох ажлын байр	Эхлэх хугацаа
Өмнөговь					
Таван толгой	Нүүрс	200+	15000	1500	2012
Ухаа худаг	Нүүрс	100	10000	1000	2009
Баруун Наран	Нүүрс	20	6000	500	2012
Цагаан толгой	Нүүрс	20	2000	150	2015
Нарийн сухайт	Нүүрс	40	2000	150	2003

¹¹ Үндэсний эдийн засгийн судалгаа, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, 2010 он.

¹² Эх үүсвэр: Оюу Толгой төсөл, Нийгэм, эдийн засаг, байгаль орчны дэд судалгаа, 2009 он.

Ордын нэр	Ашигт малтмал	Ашиглах хугацаа	Олборлолтын хэмжээ, ('000 тонн/жилд)	Шинээр бий болгох ажлын байр	Эхлэх хугацаа
Овоот толгой	Нүүрс	50	5000	400	2008
Оюу Толгой	Зэс	50	2000	4000	2012
Говь-Сүмбэр					
Сүмбэр	Нүүрс	50	5000	400	2015
Шивээ овоо	Нүүрс	200+	14000	600	2015
Дорноговь					
Цагаан суварга	Зэс	30	500 - 1.3 Сая тон зэс	1500	2015
Дундговь					
Төмөртэй	Төмөр	-	4.6	-	-
Хараат	Төмөр, цайр	-	15.0-20.0	107*	-
Эрээн	Төмөр	-	1.0	1000	-
Үнст худаг	Нүүрс	-	98.0		-

*Монгол ажилтны тоо

Говийн бүсийн Техник мэргэжлийн ур чадвар, ажиллах хүч, сургалтын судалгаа, эцсийн тайлан, 2010.10.29. Sustainability Зүүн Ази, ХХК.

Оюу Толгойн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг 2011 оны 2-р сарын байдлаар Хүснэгт 9.6-д харуулсан ба үүнд үндсэн болон гэрээт байгууллагуудын ажилтнууд хамрагдсан байна. Оюу Толгойн нийт 5,513 гэрээт ажилтны 3,789 нь буюу 68.7% нь монголчууд, 31.3% нь буюу 1,724 нь гадаадын ажилчид байна.

Хүснэгт 9.6: Оюу Толгой болон гэрээт компаниудын ажилтнуудын тоо, 2011 оны 2-р сарын байдлаар

Байгууллага	Ажилчдын тоо		
	Монгол	Гадаад	Нийт
Оюу Толгой	620	82	702
	88.3%	11.7%	100%
Гэрээт гүйцэтгэгчид	3,169	1,642	4,811
	65.87%	34.13%	100%

Эх сурвалж: Оюу Толгой, Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн сан, 2011 он 2 дугаар сар.

Оюу Толгойд ажиллаж буй гадаадын ажилчид нь бүгд гүйцэтгэх/менежментийн түвшний эсвэл техникийн мэргэжилтнүүд юм. Оюу Толгой нь ирэх 5 жилийн хугацаанд хойч үеийн мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилгоор менежментийн түвшний болон техник мэргэжлийн сургалтанд 85 сая доллар зарцуулахаар төсөвлөсөн бөгөөд улмаар Монгол ажилчдын тоо нэмэгдэх юм. Монгол Улсын засгийн газартай байгуулсан гэрээнд Монгол болон гадаад ажилчдын тооны харьцаа 90:10 байхаар заасан. Ажиллах хүчний энэхүү харьцаа зөрчигдсэн тохиодолд Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яаманд нөхөн төлбөр олгоно. Харин гэрээт компаниудын хувьд нөхцөл байдал арай өөр юм. Барилгын шатанд Засгийн газартай тохиролцсоны дагуу Монгол ажилчид болон гадаад ажилчдын харьцаа 60:40 байна.

Гар болон бичил уул уурхай

Монгол улсад гар аргаар олборлодог бичил уул уурхайн салбар байдаг ба хэсэг бүлэг хүмүүс улирлын шинж чанартай, гар аргаар ашигт малтмал олборлодог. 2007 оны 5-р сард Монгол улсын Засгийн газраас бичил уурхайнуудын үйл ажиллагааг хаасан. Гар аргаар ашигт малтмал

олборлогчид нь ямар ч бүртгэл, зөвшөөрөлгүй ажилладаг тул тэднийг хууль бус ажиллагаа явуулж байна гэж үздэг. Хууль бус гэсэн статустай тул эдгээр хүмүүсийн талаар албан ёсны мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй бөгөөд сүүлийн арван жилийн хугацаанд бичил уурхайн үйл ажиллагаа өргөжин тэлж 30,000 орчим хүнийг хамран, жилийн туршид амьжиргааных нь эх үүсвэр болдог болсон байна. Харин зуны улиралд энэ тоо 100,000-д хүрдэг байна (9.5.6-р хэсгийг үзнэ үү).

9.4.6 Бусад салбар

Хөдөлмөр эрхлэлтийн дараагийн томоохон салбар нь боловсруулах үйлдвэрлэл, худалдааны салбар бөгөөд энэ салбарт ажиллагсдын тооны эзлэх хувь 1994-2008 оны хооронд 19.5%-24.2 % хүртэл өссөн байна. Нийтийн үйлчилгээ, барилга, уул уурхай, харилцаа холбоо зэрэг салбаруудын хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувиуд нь бага зэрэг өссөн бол тээвэр, санхүү, төрийн захиргаа зэрэг салбаруудын эзлэх хувь 1994 оноос өнөөдрийг хүртэл харьцангуй тогтмол байдалтай байна.¹³

Монгол улс чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэнээр шинэ төрлийн үйлчилгээний бизнес болон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг бий болгосон. Хот суурин болон хөдөө орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл нь зоогийн газар, кафе, цэвэрлэгээ үйлчилгээ, орон байр, зочид буудал, машин засварын газар, угаалга, гар утасны засвар үйлчилгээ, мужааны газар, тээвэр зуучлал гэх мэт чиглэлээр өргөжин тэлж, хурдацтай хөгжиж байна.¹⁴

9.4.7 Орлого

2010 оны 1-р улирлын *Ажиллах хүчний судалгаагаар* айл өрхийн сарын дундаж орлого 349,100 MNT (\$233 USD) байсан ба энэ нь өмнөх оны мөн үеэс 1.6%-аар өссөн үзүүлэлт юм. 2009 оны эцсээр нэг айл өрхийн сарын зардал нь 368,300 MNT (\$245 USD) болж өмнөх оны мөн үеийнхээс даруй 0.9%-аар нэмэгдсэн байна.

9.5 ӨМНӨГОВЬ АЙМАГ

9.5.1 Нийт ажиллах хүч

Үндэсний статистикийн газрын мэдээгээр Өмнөговь аймагт АХОТ нь 2009 оны эцэст 67.7% байсан ба 2010 оны эцсээр 80.5% хүртэл өссөн байна. Энэ нь үндэсний хэмжээний дундаж үзүүлэлт болох 66.8%-аас өндөр байгаа юм. 2009 онд 15-аас дээш насны хөдөлмөр эрхэлдэг иргэдийн тоо 22,400 байснаа 2010 онд 23,200¹⁵ болж өссөн байна.

9.5.2 Ажилгүйдэл ба тогтвортой бус хөдөлмөр эрхлэлт

2010 онд Өмнөговь аймагт ажилгүйдлийн түвшин 1.8% байсан нь үндэсний дунджаас /3.3%/ доогуур байна (Хүснэгт 9.2). Өмнөговь аймагт албан ёсны бүртгэлтгүй ажилгүйдлийн тоо сүүлийн жилүүдэд өссөн нь *Ажиллах хүчний судалгаанаас* харагдаж байгаа бөгөөд 2007, 2008, 2009 онуудад бүртгэгдсэн ажилгүйдлийн хэмжээ 10.2%, 15.6%, 19.3%-тай байжээ.¹⁶

Оюу Толгойн суурь судалгаанаас үзэхэд 15 ба түүнээс дээш насны хөдөлмөр эрхэлдэг хүн амын 5.5% нь тогтвортой бус хөдөлмөр эрхэлдэг байна. Тогтвортой бус хөдөлмөр эрхлэлт гэдэгт Монгол улсад “долоо хоногт 40-өөс бага цаг ажиллаж, бусад нэмэлт орлогын эх үүсвэр хайдаг хүмүүсийг” багтаан авч үздэг. Үндэсний Статистикийн Газрын сар бүрийн мэдээ болон жилийн эцсийн тайланд тогтвортой бус хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдээлэл байдаггүйг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Суурь судалгаагаар Өмнөговь аймагт бүрэн дунд боловсрол эзэмшээгүй иргэд болон залуучууд, эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин өндөр байгааг тогтоосон байна.

¹³ *Ibid*, Эдийн засгийн сургууль, 2011 он.

¹⁴ Монгол улсын эдийн засгийн улирлын мэдээ, Дэлхийг Банк, 2011 он 1-р сар

¹⁵ Статистикийн сарын мэдээ, ҮСГ, 2010 он 2-р сар

¹⁶ *Ibid*, ҮСГ, 2010 он.

9.5.3 Эдийн засгийн салбар

Өмнөговь аймгийн оршин суугчдын ихэнх нь ХАА-н салбарт эдийн засгийн идэвхитэй ажилладаг бөгөөд нийт ажиллах хүчний 63.1% нь мал аж ахуйн салбарт ажиллаж байна. Эдийн засгийн бусад салбар нь ХАА-н салбартай харьцуулахад маш бага хувь эзэлж байгаа бөгөөд харьцангуй өндөр хувь эзэлдэг салбарууд нь: 8.9% бөөний болон жижиглэнгийн худалдаа, 8.2% төр захиргаа, 4.7% боловсрол, 4.2% уул уурхайн салбарууд юм. Гэсэн хэдий ч эдгээр тоо баримтууд нь сүүлийн жилүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хандлагыг тусган харуулж чадахгүй бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн мэдээг салбар бүрээр нь болон аймаг тус бүрээр нь 2008 оноос хойш ангилан судалж олон нийтэд ил болгоогүйг тэмдэглэх нь зүйтэй.

9.5.4 Мал аж ахуйн үйлдвэрлэл

Өмнөговь аймгийн хүн амын дийлэнх хувийг малчид эзлэдэг. Аймгийн нийт 13,220 өрхийн 7,305 нь буюу 55.2% нь малтай өрх байна. Тэдний 6,258 өрх нь буюу 47.3% нь амьжиргаагаа мал аж ахуйгаар залгуулдаг¹⁷. Аймгийн 14,000¹⁸ орчим хүн ам мал маллаж, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг амин зуулгаа болгон, малын гаралтай түүхий эд материалыг борлуулж орлогоо залгуулдаг байна.

2003 оноос хойш аймгийн мал сүргийн тоо толгой 70%-аар өсчээ. Малчин өрхийн ихэнх нь 100-аас 500 толгой малтай бөгөөд түүний ихэнх хувийг нь ямаа эзэлдэг. Малчид ямаа, хонь, тэмээн сүргийнхээ тоо толгойг өсгөхийг илүү чухалчилдаг нь эдгээр мал нь морь, үхэртэй харьцуулахад илүү эдийн засгийн ашигтай байдагтай холбоотой юм /ялангуяа ямааны ноолуур/.

Өмнөговь аймгийн малын гаралтай бүтээгдэхүүний дийлэнх хувь нь амин зуулгад зарцуулагдах буюу орон нутгийн зах зээл дээр борлуулагддаг /ямааны ноолуурыг Хятадын хилийн боомт дээр зарж борлуулдаг/. Малын гаралтай бүтээгдэхүүнд: амьд мал, тэмээний ноос, ноолуур, хонины ноос, малын арьс шир зэрэг орно. Суурь судалгаанд хамрагдсан ихэнх малчин өрхүүдийн амьжиргааны хамгийн найдвартай эх үүсвэр нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүд хэмээн хариулсан юм.

Сумын төвд амьдардаг малчид нь мал аж ахуй эрхлэхээс гадна дэлгүүр хоршоо ажиллуулах, улирлын чанартай ажил хөдөлмөр эрхлэх зэргээр нэмэлт орлого олдог байна. Орлого, өмч хөрөнгийн хэмжээгээр эдгээр малчид нь өөр өөр хэдий ч гадны нөлөөлөл болох байгалийн гамшиг, ган, зуд¹⁹, үнийн хэлбэлзэл, худалдааны эргэлт муудах, эдийн засгийн эрсдэл, газар ашиглах маргаан /ашигт малтмалын ордоос үүдэлтэй/ зэрэгт эмзэг байдаг. Ханбогд сумын малчдын орлого, амьжиргааны эх үүсвэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 9.6.4-өөс үзнэ үү.

9.5.5 Газар тариалан

Мал аж ахуйтай харьцуулахад газар тариалан нь орон нутгийн иргэдийн орлогод бага хувь нэмэр оруулдаг. Гэхдээ төмс, хүнсний ногооны тариалалт нь зарим өрхийн амьжиргаанд чухал үүрэгтэй байдаг байна. Оюу Толгой нь газар тариаланг өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Даланзадгад хотын хөдөө аж ахуйн хоршооллыг өргөжүүлж, төслийн хэрэгцээнд хүнсний ногоо нийлүүлэх төслийг хэрэгжүүлж эхлээд байна. (Зураг 9.2) Малын тэжээл үйлдвэрлэх нь чухал боловч хангалттай тариалангийн талбай байхгүй байна. 2003 – 2007 онуудад Ханбогд суманд 316 тонн өвс хураан авсан нь малтай айл өрх бүрт 0.4-0.9 тонн өвс, өвсөн тэжээл ноогдож байсан юм.

¹⁷ Өмнөговь аймгийн Статистикийн газар, 2010, Оюу Толгой 2011 онд материал болгон цуглуулсан.

¹⁸ Нийт 22.2 мянган ажилтай иргэд байдаг ба ХАА-н салбарт 63.1% нь ажилладаг, 2008 оны Статистикийн лавлах

¹⁹ Зуд гэдэг нь цас ихтэй хүйтэн өвлийг хэлэх ба мал амьтад цасны зузаан давхаргыг давж өвсөө олж идэж чаддаггүй бөгөөд өлсгөлөн болон хүйтний улмаас олон мал үхдэг.

Зураг 9.2: Оюу Толгойн төсөлд хүнсний ногоо нийлүүлдэг Даланзадгад сумын ХАА-н хоршоолол



Эх сурвалж: Оюу Толгой, 2010 онд авсан зураг

9.5.6 Уул уурхай

Өмнөговь аймагт энэхүү суурь судалгааг хийх үед нөөц нь тогтоогдсон нүүрс, алт, зэсийн 42 орд газар нээгдсэн байсан. Харамсалтай нь, уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлтийн талаар сүүлийн үеийн судалгаа хийгдээгүй. 2006-2007 оны *Ажиллах хүчний судалгаагаар* аймгийн хүн амын 4.2% нь буюу 1,000 хүрэхгүй тооны хүн уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлдэг гэсэн тооцоо гарчээ. Уул уурхайн салбарын хөдөлмөр эрхлэлт түүнээс хойш ихээхэн нэмэгдсэн нь эргэлзээгүй бөгөөд үүнийг Оюу Толгойн ажилтнуудын тооноос (Хүснэгт 9.7) харж болно. Оюу Толгой төсөл дээр Өмнөговь аймгийн нийт 1,069 иргэн ажиллаж байгаагаас 564 нь эрэгтэй, 485 нь эмэгтэй хүмүүс байна.

Хүснэгт 9.7: Оюу Толгой төслийн ажилчдын тоо, оршин суудаг харъяалалаар, 2010 оны 12-р сар

Хүйс	Ханбогд	Баян-Овоо	Манлай	Даланзадгад	Бусад сум	Нийт
Оюу Толгой						
Эр	23	5	7	64	14	113
Эм	11	1	5	18	2	37
Нийт	34	6	12	82	16	150
Бусад						
Эр	260	14	28	163	4	469
Эм	335	12	26	77	—	450
Нийт	595	26	54	240	4	919
Нийт						
Эр	283	19	35	227	18	582
Эм	346	13	31	95	2	487
Нийт	629	32	66	322	20	1,069

Эх сурвалж: Олон нийт болон нийгмийн асуудал эрхэлсэн хэлтэс, сар тутмын тайлан, 2010 оны 12-р сар, Оюу Толгойн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн сан

Гар болон бичил уурхай

Өмнөговь аймагт гар болон бичил уурхай байдаг боловч Оюу Толгой төслийн ойр орчимд байдаггүй нь энэ хавийн хөрсний давхаргууд болон чулуулаг давхаргуудад гар аргаар олборлох боломжтой алтны агууламж байхгүйтэй холбоотой юм. Төслийн талбайтай хамгийн ойр байрлах энэ төрлийн бичил уурхай нь Ирак толгой хэмээх газарт, төслийн талбайгаас 135 км-н зайд, Дорноговь аймгийн Хатанбулаг болон Өмнөговь аймгийн Номгон сумдын нутагт /Баян Овоо сумаас баруун тийш/ төслийн талбайн гадна талд байрладаг. Засгийн газраас машин механизм, тоног төхөөрөмжийг нь улсын өмч болгон хураахаас өмнө Ирак толгой хэмээх газарт 19 хууль бус тээрэм ажиллаж байсан.

Суурь судалгаагаар Өмнөговь аймгийн нийт айл өрхийн 10 гаруй хувь нь хууль бусаар алт олборлох ажиллагаанд оролцдог гэж тогтоожээ. Засгийн газраас хууль бусаар алт олборлоход хориг тавьж, үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь тэдний орлогод муугаар нөлөөлсөн гэж мэдээлж байсан ч Засаг даргын саяхны мэдээлснээр хууль бус алт олборлосноос үүдсэн эдийн засгийн хүндрэл нь түр зуурынх байсан бөгөөд одоо тэдгээр хувиараа ашигт малтмал олборлогчид нь өөр чиглэлээр ажил хөдөлмөр эрхэлдэг болсон байна.

9.5.7 Жижиг дунд бизнес

Суурь судалгааны хүрээнд Өмнөговь аймгийн хувийн хэвшлийн жижиг дунд аж ахуйн нэгжүүд болон хувиараа бизнес эрхлэгчдийн талаар үнэлгээ хийж, үүндээ албан ёсны бүртгэлтэй, бүртгэлгүй аж ахуйн нэгжүүдийг бүгдийг нь хамруулжээ.

Тус аймагт худалдаа арилжаа, зочид буудал, хоолны газар ажиллуулах, модон эдлэл үйлдвэрлэх, ачаа болон зорчигч тээврийн үйлчилгээ зэрэг 40 гаруй төрлийн гэр бүлийн жижиг бизнесүүд үйл ажиллагаа явуулж байгааг тогтоосон байна.

Жижиг дунд бизнес нь айл өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд томоохон түлхэц болдог бөгөөд сумын төвийн айл өрхийн 12%, малчдын 7% нь жижиг дунд бизнесийн үйл ажиллагаа явуулж нэмэлт орлого олдог нь Суурь судалгаагаар тогтоогдсон байна. Өмнөговь аймагт ирэх гадаадын жуулчдын тоо сүүлийн жилүүдэд өсч байгаа ба аймгийн аялал жуулчлалын салбарт 2008 онд нийтдээ 344 хүн ажиллаж байсан бөгөөд тэдний 21.5 % нь байнгын, 68.5 % нь улирлын чанартай ажил эрхэлж байна.²⁰ Аймгийн хэмжээнд 2008 онд 23 жуулчны бааз байсан ба эдгээр нь 577 гэр, 1,548 ортой байв. Эдгээр жуулчны баазуудын 3 нь Даланзадгад хотод, 3 нь Ханбогд суманд байрлаж байна.

9.5.8 Ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн оролцоо

Суурь судалгаагаар аймгийн хэмжээнд эмэгтэйчүүдийн АХОТ 64.5%, эрчүүдийнх 67.2% байгааг тогтоосон. Аймгийн хэмжээнд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн ихэнх хувь нь мал маллах, малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт, борлуулалтад ноогдож байна.²¹ Сумын төвд эмэгтэйчүүд голдуу цайны болон зоогийн газар, үсчин, талх нарийн боовны цех зэрэг жижиг бизнест оролцож, зарим нь цалинтай ажил хийдэг. 2007 онд Өмнөговь аймагт 2,414 төрийн үйлчилгээний албан хаагч байсны 1,665 нь буюу 69% нь эмэгтэйчүүд байсан.

Эндээс харахад эмэгтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн талаарх ойлголт өөрчлөгдөж, өрхийн орлогоо нэмэгдүүлж, өрхийн эдийн засагт зохих түлхэц болж байгаа эмэгтэйчүүдийн тоо өсч байгааг тэмдэглэх нь зүйтэй. Судалгааны бүлгийн уулзалтын үеэр суурь судалгаанд оролцогсод энэ бүс нутагт эмэгтэйчүүд өрхийн амьжиргаанд чухал хувь нэмэр оруулж байна гэдгийг онцлон дурдаж байсан.

²⁰ Оюу Толгой төсөл, Нийгэм, эдийн засаг, байгаль орчны дэд судалгаа, 2009 он.

²¹ *Ibid*, Дэд судалгааны тайлан, 2009 он.

9.5.9 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

Өмнөговь аймгийн хүн амд залуучуудын эзлэх хувь нь улсын дунджаас өндөр байдаг. Судалгааны үеэр Ханбогд, Баян-овоо, Манлай, Цогтцэций сумдын 17-42 насны 40 хүнтэй биечлэн уулзсан ба тэдний 47.8% нь эр, 52.2% нь эмэгтэйчүүд байв. Насны ангилалаар авч үзвэл 16.8% нь 17-19 насны, 36.6% нь 20-24 насны, 23.6% нь 25-29 насны, 13.0% 30-34 насны, 10% нь 35-42 насны иргэд байлаа. Нийт судалгаанд хамрагдсан залуусын 77% нь 30-аас доош насны иргэд байсан. Судалгаанд оролцогсдын 26.7% нь ХАА-н салбарт /ялангуяа мал аж ахуйн салбарт/, 23.6% хувиараа хөдөлмөр эрхлэгч, 16.1% төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад, 16.8% ажилгүй, бусад нь үйлчилгээний байгууллагад ажилладаг иргэд байв.

9.5.10 Хүүхдийн хөдөлмөр

Суурь судалгаанд аймгийн 1,325 өрхийн 1,545 хүүхэд хамрагдсан бөгөөд 5-17 насны хүүхдүүдийн 4.6% нь хөдөлмөр эрхэлдэг байсан бөгөөд эдгээр хүүхдүүдийн гуравны хоёр нь эрэгтэй хүүхэд байв. Нийт хүүхдийн 60 гаруй хувь нь мал аж ахуй салбарт ажилладаг бол 7% нь үйлдвэрлэл, барилгын, 6.5% нь худалдааны, 3.6% нь газар тариалан, 2% нь аялал жуулчлал, 3% нь хууль бус бичил уурхайд тус тус хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн ихэнх нь ядуу өрхийн амьдралдаа дэм болж, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор ажиллаж байна. Оюу Толгой болон энэ бүс нутагт хэрэгжиж буй бусад олон улсын уул уурхайн төслүүд нь насанд хүрээгүй хүүхэд хөдөлмөр эрхлэх явдлыг хориглодог гэдгийг энд онцлон тэмдэглэх хэрэгтэй.

9.5.11 Орлого ба зарлага

Орлогын эх үүсвэр

2008 онд Өмнөговь аймагт нэг өрхийн сарын дундаж орлого 523,406 (USD \$376) төгрөг байсан байна. Орон нутгийн эдийн засагт нь уул уурхай, үйлдвэрлэлийн салбар давамгайлсан Цогтцэций сумын хувьд энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу нэг өрхийн сарын дундаж орлого нь 620,106 (USD\$413) төгрөг байв. Хүснэгт 9.8-д өрхийн орлогын эх үүсвэрийг хувь хэмжээгээр, Хүснэгт 9.9-т суурь судалгаагаар цуглуулсан өрхийн сарын нийт орлогын эх үүсвэрүүдийг тус тус тодорхой харуулав.

Хүснэгт 9.8: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн сарын дундаж орлогын бүтэц /%/

Сумын нэр	Нийт мөнгөн орлого (%)	Нийт мөнгөн орлогод эзлэх хувь /%/					Бусад орлого (%)	
		Цалин	Тэтгэвэр, тэтгэмж	МАА-н орлого	Газар тариалангийн орлого	Гэр бүлийн бизнесийн орлого	Бусдаас өгсөн бэлэг, тэтгэмж	Амин зуулгын ХАА
Баян-Овоо	66.4	24.3	22.9	36.1	0.4	16.3	6.7	26.9
Манлай	69.1	24.2	23.8	43.7	0.1	8.2	1.5	29.4
Ханбогд	77.9	38.3	18.8	29.6	0.0	13.3	2.1	20.0
Цогтцэций	74.9	37.7	23.7	29.7	0.4	8.6	2.8	22.3
Даланзадгад	87.6	56.4	24.9	4.2	1.3	13.1	7.5	4.9
Аймгийн дундаж	74.4	35.2	22.8	27.9	1.4	12.7	3.9	21.7

Эх сурвалж: ОТ төсөл Нийгэм, эдийн засаг, Байгаль орчны дэд судалгаа, 2009 он.

Хүснэгт 9.9: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн сарын нийт орлого бэлэн мөнгөөр

Сумын нэр	Айл өрхийн нийт орлого	Нийт мөнгөн орлого	Мөнгөн орлогын бүтэц					Бусад орлого	
			Цалин	Тэтгэвэр тэтгэмж	МАА-н орлого	Газар тариалангийн орлого	Гэр бүлийн бизнесийн орлого	Бусдаас өгсөн бэлэг	Өөрийн өрхийн хүнсээ бэлдэх
Баян-Овоо	510,223	347,710	94,520	58,942	113,451	543	80,254	17,267	145,246
Манлай	500,799	358,657	96,642	60,266	173,298	625	27,826	4,803	137,339
Ханбогд	574,838	458,201	169,770	50,599	146,794	46	90,991	6,622	110,015
Цогтцэций	620,106	510,692	189,931	55,185	100,764	2,652	162,160	10,381	99,032
Даланзадгад	471,132	417,220	245,577	56,878	16,185	4,954	93,626	28,771	25,140
Аймгийн дундаж	523,406	397,729	152,791	54,747	90,589	5,764	93,837	13,888	111,789

Тусгай тэмдэглэл: US\$1=1,500 төгрөг

Эх сурвалж: Оюу Толгой төсөл, Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны дэд судалгаа, 2009 он.

Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхийн нэг хүнд ноогдох сарын дундаж орлого 100,766 төгрөг (USD \$67) байсан бол уул уурхай, олборлолтын салбарт ажилладаг өрхийн нэг хүнд ноогдох орлого дээрхээс хоёр дахин их буюу 232,601 (USD \$155) байсан (Хүснэгт 9.10-г харна уу).

Хүснэгт 9.10: Сарын дундаж орлого /эрхэлж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбараар/

Сумын нэр	Судалгаанд хамрагдсан хөдөлмөрийн насны ажил эрхэлдэг иргэдийн тоо	Сарын дундаж орлого /төгрөг/		
		МАА, ой болон загасны аж ахуй	Газар тариалан	Уул уурхай
Баян-Овоо	84	95,228	-	114,660
Манлай	125	125,173	-	150,000
Ханбогд	215	132,422	-	267,381
Цогтцэций	137	79,801	-	251,760
Даланзадгад	572	89,141	8,676	287,053
Аймгийн дундаж	2,288 нийт	100,766	67,876	232,601

Эх сурвалж: Оюу Толгой төсөл, Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны дэд судалгаа, 2009 он.

Зардал

Суурь судалгаанд хамрагдагсдын хувьд нэг хүнд ноогдох сарын зарлага нь 2008 оны байдлаар 146,390 (US\$98) төгрөг байжээ. (Хүснэгт 9.11) Нэг хүнд сард ноогдох зарлагын хэмжээг харахад хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүнд зарцуулсан зарлагууд нь тэнцүүхэн байна /Баян-Овоо сумаас бусад сумдад/.

Хүснэгт 9.11: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн нэг хүнд ноогдох сарын зарлага

Зардлын категори	Баян-Овоо	Манлай	Ханбогд	Цогтцэций	Даланзадгад	Аймгийн дундаж
Хэрэглээ (₮/сард)						
Хүнс	75,754	58,800	52,820	57,399	57,085	68,896
Өргөн хэрэглээний бараа	4,297	5,670	7,183	4,882	5,747	5,848
Дулаан, байр	2,278	3,823	2,987	1,503	4,341	2,673
Хүнсний бус бусад	49,625	60,418	83,380	57,756	75,064	68,972
Нийт	131,954	128,711	146,369	121,540	142,236	146,390
Хэрэглээ (% эзлэх хувь)						
Хүнс	58.2	50.8	43.9	49.4	46.0	51.6
Өргөн хэрэглээний бараа	3.4	4.2	4.3	3.6	3.8	3.7
Дулаан, байр	2.0	2.8	2.4	1.3	2.8	1.9
Хүнсний бус бусад бараа	36.4	42.2	49.4	45.6	47.4	42.7

US\$1=1,500 төгрөг

Эх сурвалж: Оюу Толгой төсөл, Нийгэм, эдийн засаг, байгаль орчны дэд судалгаа, 2009 он.

Суурь судалгаанд хамрагдсан бүлгийн уулзалтын дүнгээс харахад судалгаанд оролцогсдын хувьд өрхийн орлогыг гэр бүлийн гишүүд нь хэрэгцээнээсээ хамааран эрх тэгш хуваарилан зарцуулдаг ба өрхийн тэргүүний шийдвэрийг дагадаг байна. Тэдний ярьснаар бол өрхийн зарлагад хүүхдүүддээ зарцуулах зарлага хамгийн өндөр байдаг бөгөөд энэ нь голдуу сургалтын төлбөр, ном сурах бичиг, сургуулийн хувцас зэрэгт зарцуулагддаг байна. Энэхүү дүгнэлт нь Оюу Толгойн Ханбогд сумын малчин өрхүүдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлгийн үр дүнгээр мөн баталгаажуулагдсан юм. Оюу Толгой төслийн газар ашиглалтын нөлөөлөлд өртсөн байж болох малчин өрхүүд хүүхдийнх нь сургалтын төлбөрийг төлөх байдлаар амьдрал ахуйг нь сэргээхэд туслана уу гэсэн хүсэлтийг гаргаж байсан. (Бүлэг D26: Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө).

9.5.12 Орлогыг дэмжих нь

Суурь судалгаагаар санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй үед хүн амын хувьд орлогын дэмжлэг, нийгмийн халамж авах бололцоо нөхцөл нь хэр байсныг судалсан бөгөөд судалгаанд оролцсон Өмнөговь аймгийн айл өрхүүдийн 93% нь санхүүгийн хүндрэлтэй байсан үед тусламж дэмжлэг авах бололцоо нөхцөл байсан гэж хариулсан байна (Хүснэгт 9.12-г харна уу). Судалгаагаар аймгийн нийт айл өрхүүдийн 50% нь жилд хамгийн багадаа нэг удаа зээл авч зээлийнхээ 60%-г нь өрхийн хэрэглээндээ, 10%-г нь хөдөө аж ахуйн зориулалтаар буюу мал худалдан авахад зарцуулжээ. Зээлийн ихэнх хувийг арилжааны банкнаас авсан ба 5 хүрэхгүй хувийг хувь хүн, хувийн санхүүгийн байгууллагуудаас авсан байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд нийт өрхийн 63 орчим хувь нь санхүүгийн хүндрэл бэрхшээл тохиолдсон үед ах дүү, хамаатан саднаасаа дэмжлэг туслалцаа эрдэг бөгөөд хамаатан садны харилцаа, үнэ цэнэ нь чухал хэвээрээ байгаа гэсэн байна. Аймгийн нийт айл өрхийн 22% нь найз нөхдөөсөө, 14% нь хамтран ажиллагсдаас, 13% нь сумын захиргааны байгууллагаас санхүүгийн дэмжлэг туслалцаа авах боломжтой гэсэн байна. Судалгааны дүнгээс харахад сумын иргэд малаа арилжаалж борлуулах, хөлсөөр ажиллах, бусад хүмүүсийн малыг хөлсөөр хариулах, жолооч хийх гэх мэт нэмэлт ажил хийж тулгарсан санхүүгийн бэрхшээлээ шийддэг байна.

Хүснэгт 9.12: Айл өрхүүдийн санхүүгийн тусламж дэмжлэг авдаг газрууд %

Төрөл /категори/	Сум					
	Баян-Овоо	Манлай	Ханбогд	Цогцэций	Даланзадгад	Аймгийн дундаж
Санхүүгийн хүндрэлтэй үед айл өрхүүдийн тусламж авахаар ханддаг газрууд (%)						
Хамаатан садан	58.7	62.5	69.7	53.0	69.8	62.8
Найз нөхөд	41.3	10.9	9.2	9.1	35.6	21.5
Хамт ажилладаг хүмүүс	6.5	6.3	5.5	7.6	28.8	14.2
Орон нутгийн чинээлэг, эрх мэдэлтэй хүмүүс	2.2	0.0	0.0	1.5	0.5	1.1
Засаг захиргаа	32.6	7.8	22.9	24.2	5.1	13.4
Төслийн байгууллагууд	0.0	0.0	0.9	0.0	0.0	0.7
Банк	23.9	17.2	12.8	16.7	12.9	17.3
Дэлгүүр, ТҮЦ	0.0	6.3	0.0	3.0	0.3	1.0
Бусад	2.2	0.0	2.8	0.0	1.1	2.5
Байхгүй	13.0	15.6	10.1	13.6	15.4	15.6
Санхүүгийн хүндрэлтэй тулгарахаараа хэрэглэдэг арга (%)						
Малаа зарж борлуулах	67.4	56.3	45.9	45.5	7.8	40.2
Засаг захиргаанаас тусламж хүсэх	15.2	4.7	9.2	10.6	4.9	7.6
Жижиг бизнес эрхлэх	6.5	10.9	14.7	15.2	17.3	13.8
Уул уурхай	0.0	0.0	7.3	6.1	12.4	9.9
Бусдад ажиллах	28.3	29.7	33.9	30.3	48.0	30.2
Зээл авах	20.0	12.1	8.6	12.3	22.1	15.8
Бусад	3.9	2.0	3.3	4.4	10.0	5.1
Санхүүгийн тусламж авч чаддаг эсэх (%)						
Тийм	92.5	98.1	99.0	96.5	94.6	93.6
Үгүй	7.5	1.9	1.0	3.5	5.4	6.4
Тусламжийн хэлбэр* (%)						
Мөнгөн тусламж	78.4	86.8	84.5	87.3	85.2	82.4
Эд материалын тусламж	32.4	39.6	28.9	25.5	50.8	39.6
Урам зориг авах	29.7	13.2	35.1	18.2	56.9	42.5
Ажил олж өгөх	16.2	3.8	3.1	1.8	0.7	3.4
Төсөлд хамруулах	2.7	0.0	1.0	1.8	0.3	1.5
Бусад	10.8	0.0	1.0	0.0	3.7	3.3
Мөнгөн болон эд материалын тусламжийг эргүүлэн төлдөг эсэх? (%)						
Тийм	45.9	7.5	20.6	10.9	32.7	31.4
Үгүй	54.1	92.5	79.4	89.1	67.3	68.6
Хэрэв тийм бол яаж?* (%)						

Төрөл /категори/	Сум					
	Баян-Овоо	Манлай	Ханбогд	Цогцэций	Даланзадгад	Аймгийн дундаж
Мал маллахад туслах	47.1	25.0	15.0	50.0	8.2	28.7
МАН-н үйлдвэрлэлд туслах	64.7	0.0	10.0	0.0	10.3	19.8
Малын тэжээл бэлтгэхэд туслах	29.4	0.0	10.0	0.0	3.1	15.9
Аргал түүхэд туслах	29.4	0.0	5.0	0.0	2.1	11.9
Гэр орны ажилд нь туслах	76.5	25.0	30.0	16.7	32.0	33.2
Хашаа хороо барихад нь туслах	17.6	0.0	10.0	0.0	5.2	10.7
Буцаан төлдөг	3.0	0.0	40.0	35.0	60.0	34.4
Бусад	2.9	0.0	10.0	15.0	8.0	10.7

Эх сурвалж: ОТ төсөл, Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны дэд судалгаа, 2009 он

* олон хариулттай асуултууд

9.6 ХАНБОГД СУМ

9.6.1 Нийт ажиллах хүч

Суурь судалгааны дүнгээс үзэхэд 2008 онд Ханбогд сумын нийт оршин суугчдын 48.6% нь ХАА-н салбарт ажиллаж байсан ба мал аж ахуй эрхлэх нэтэдний өрхийн амьжиргааны гол эх үүсвэр нь болж байсан байна. Ханбогд сумын хөдөөгийн иргэдийн хувьд мал маллах нь эрхэлдэг гол ажил хөдөлмөр нь байсан ба одоо ч байсаар байна. 2010 оны байдлаар Ханбогд суманд бүртгэлтэй нийт 1,112 айл өрхийн 639 нь малчин айл өрх байна (Бүлэг В8: Хүн ам, хүн ам зүй). Суурь судалгаа явуулснаас хойш цалинтай ажил хөдөлмөр эрхэлдэг иргэдийн тоо ялангуяа уул уурхайн салбарт нэмэгдсэн нь Оюу Толгой төслийн бүтээн байгуулалттай холбоотой юм.

Өмнөговь аймгийн Статистикийн хэлтсийн мэдээгээр Ханбогд суманд ажил эрхэлдэг 1,455 хүн байгаагийн 721 нь эр, 734 нь эмэгтэйчүүд байна /ажил эрхлэлтийн түвшин 69.4%/. Харин 2010 оны сүүлээр ажил эрхлэлтийн түвшин эрс нэмэгдэж /хэдийгээр сумын хүн амын тоо өссөн боловч/, нийт ажил эрхэлдэг иргэдийн тоо сумын хэмжээнд 1,849-д хүрсэн ба тэдний 965 нь эр, 884 нь эмэгтэйчүүд болсон байна.

9.6.2 Ажилгүйдэл

2010 оны 3-р сарын байдлаар Ханбогд сумын Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 471 байсан бөгөөд 2010²² оны 3-р сараас хойш Оюу Толгойн ажилчдын тоо эрс нэмэгдсэн тул сумын ажилгүйчүүдийн тоо түүнээс хойш ихээхэн багассан гэсэн хүлээлттэй байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст шинэчлэгдсэн тоо баримт байхгүй байсан бөгөөд хүн амын тооллого бүртгэлийн эцсийн дүн 2011 оны 7-р сард гарна.


9.6.3 Эдийн засгийн салбар

Зураг Зураг 9.3-т үзүүлснээр 2007 онд Ханбогд сумын эдийн засгийн идэвхитэй ажиллах хүчний бараг тал хувь нь буюу 49% нь ХАА-н салбарт ажиллаж байгаа бол 32% нь үйлчилгээний болон

²² Энэхүү тоо баримтад ажилгүй болон тогтвортой бус ажилтай гэж бүртгэгдсэн иргэдийг хамруулсан ба ОТ төсөлд шаардлагатай ажиллах хүчний тоог гаргахад сумын засаг захиргаа ихээхэн тусламж үзүүлсэн. Хэдийгээр малчид болон сумын төвийн иргэдээр ангилсан задаргаа байгаагүй хэдий ч ажиллах хүчний жагсаалтад ажилгүй малчин, сумын төвийн иргэд, улирлын чанартай ажил эрхлэдэг иргэн, шинээр ажил хайж буй иргэд, түр ажиллаагүй байгаа хүмүүс зэргийг бүхэлд нь оруулсан.

бусад салбаруудад ажиллаж байна. Хүн амын тавны нэг буюу 20% нь аж үйлдвэрийн /уул уурхай, олборлолтын салбарууд үүнд багтана/ салбарт хөдөлмөр эрхэлж байна. Эдийн засгийн гол секторуудыг доорхи хүснэгтээс үзнэ үү.

Зураг 9.3: Ханбогд сумын хөдөлмөр эрхлэлтийг эдийн засгийн салбар тус бүрээр нь харуулсан байдал, 2007 он



Эх сурвалж: Оюу Толгой төсөл, Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны дэд судалгаа, 2009 он

9.6.4 Мал аж ахуйн үйлдвэрлэл, нүүдлийн мал аж ахуй

Ханбогд сумын хэмжээнд нийт 650 гаруй өрх айл малтай байна. Энэ тоонд нүүдэлчин малчид, мөн малтай боловч сумын төвд түр буюу байнга оршин суудаг айл өрхийн тоог хамруулсан (Бүлэгт В8:Хүн ам, хүн ам зүй).

Оюу Толгой нь Ханбогд сумын төслийн нөлөөлөлд өртсөн байж болох 84 малчин өрхийн гишүүдтэй уулзалт ярилцлага зохион байгуулж, өрхийн орлогын эх үүсвэр, зарлагын бүтэц, хүн ам зүйн байдлын талаар дэлгэрэнгүй судалгаа явуулжээ. Энэхүү судлагаагаар цуглуулсан амьжиргааны талаарх гол мэдээллүүдийг Хүснэгт 9.13-д харуулав. Судалгаанд 84 айл өрхийн 387 иргэн буюу 100 малчин гэр бүл хамрагдсан.²³

Хүснэгтээс харахад нэг малчин өрхийн жилийн дундаж мөнгөн орлого 5,900,000 төгрөг (US\$3,944) байгаа ба сарын дундаж орлого нь 493,034₮ (US\$329) байна. Энэ нь сумын өрхийн дундаж орлогоос арай доогуур үзүүлэлт хэдий ч улсын дундаж дүнгээс дээгүүр байна. Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан өрхүүдийн орлогын хэмжээ харилцан адилгүй байсан ба хамгийн бага нь жилийн 1,000,000 төгрөг (\$666 USD) байсан бол хамгийн өндөр нь 20,000,000 (\$13,300 USD) төгрөг байв. Энэ нь малчид нэмэлт орлогоо мал аж ахуйгаас гадна цалин хөлстэй ажил эрхлэх болон жижиг бизнес зэргээс бүрдүүлдэг болж байгааг харуулж байна. Энэхүү тоо баримтыг өрхийн судалгаанаас малчдын хэлсэн дүнгээр авсан тул зарим орлого дутуу, орхигдсон байх талтай болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Ханбогд сумынхан ямаа, тэмээ, хонь зэрэг малаа өсгөх түлхүү сонирхолтой. 2003-2010 оны хооронд Ханбогд сумын мал сүргийн тоо толгой 53,000-аас 116,000 болтлоо өсөн нэмэгджээ.

²³ Жич: Өрх айл гэдэг нь дотроо нэг буюу түүнээс дээш тооны гэр бүлийг багтаасан байна. Тухайлбал нэг өрхөд эхнэр нөхөр 2 хүүхдийн хамт, эцэг эхийнхээ дэргэд амьдарч байна. Иймд нийт гэр бүлийн тоо нь айл өрхийн тооноос их байсан. Айл өрхийн тоо нь янз бүрийн судалгаануудад өөр өөрөөр тоологдсон байж болох ба энэ нь айл өрх, гэр бүлийг арай өөр аргаар тоолдогтой холбоотой юм. Мөн түүнчлэн өөр газар амьдардаг гэр бүлийн гишүүн, оюутан, насанд хүрсэн гэр бүлийн гишүүнийг өрхийн гишүүний тоонд оруулан ихэнхдээ тооцдог. Учир нь тэд бүгд гэр бүлээсээ хараат, санхүүгийн дэмжлэг авдаг байна.

Өмнөговь аймгийн Статистикийн хэлтсийн мэдээгээр Ханбогд сумын мал сүргийн бүтэц 2010 оны байдлаар ямаа 50% орчим, хонь 25% орчим, наймны нэг нь тэмээ харин үлдсэн хувь нь үхэр, адуу байна.

Ханбогд суманд ямааны тоо толгой ихээр нэмэгдсэн нь ноолуурыг нь борлуулдагтай холбоотой бөгөөд БНХАУ-тай хил залгаа оршдог, хоёр улсын хооронд хилийн боомтууд шинээр нээгдсээр байгаа зэргээс үзэхэд ямааны тоо толгойн өсөлт ойрын ирээдүйд буурахгүй байх хандлагатай байна. Малчин айл өрхийн нийт орлогын 46% нь ноолуурын борлуулалтаас, 25% нь цалин, тэтгэврээс, 20% нь ноосны борлуулалтаас, 6% нь мах, 3% нь сүү цагаан идээ борлуулсны орлогоос тус тус бүрддэг. Малчин өрхийн хувьд ноос, ноолуур нь өрхийн орлогын бүрдүүлэлтэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг. Судалгаанд хамрагдсан 100 иргэний бараг 97% нь орлогынх нь тодорхой хэсэг ноолуурын борлуулалтаас, 81% нь ноос, 37% цалин тэтгэвэр²⁴, 29% нь мах махан бүтээгдэхүүн, 24% сүү сүүн бүтээгдэхүүн борлуулснаас бүрддэг гэж мэдээлжээ. Ноос, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн нь амин зуулгад хэрэглэгддэг бол бусад бүтээгдэхүүнүүдийг орон нутгийн зах дээр борлуулдаг. Ханбогд сумын хувьд ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг борлуулахад тохиолддог гол хүндрэлүүд нь зах зээл багатай, үнэ доогуур байдгаас шалтгаалдаг байна. Малчин өрхийн амьжиргаа, газар ашиглалт ба газраас хамааралтай ахуй амьжиргааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг В10: Газар ашиглалт-аас үзнэ үү.

Хүснэгт 9.13: Ханбогд сумын малчдын ахуй амьжиргааны гол тоо баримтууд, 2011 он

Категори	Дүн	Нэгж	Эзлэх хувь, %
Хүн ам зүй			
Өрхийн хэмжээ (дундаж)	4.6	Хүн	—
Гэр бүлийн хэмжээ (дундаж)	3.9	Хүн	—
Томоохон айл өрх (6+ гишүүдтэй)	18	Өрх	21%
Ганц хүнтэй өрх	8	Өрх	10%
Жилийн орлого (өрхийн)*			
Дундаж	5,900,000	₮	—
Хамгийн өндөр	20,000,000	₮	—
Хамгийн бага	1,000,000	₮	—
Жилийн орлогын түвшин (өрхийн)¹			
2,000,000 хүртэл (₮)	13	Өрх	18%
2,000,001 to 5,000,000 (₮)	27	Өрх	38%
5,000,001-ээс дээш (₮)	32	Өрх	44%
Нийт орлого	72	Өрх	100%
Орлогын эх үүсвэр (дундаж)			
Ноолуур	46	%	—
Ноос	20	%	—
Сүү	3	%	—
Мах	6	%	—
Бусад (цалин/тэтгэвэр)	25	%	—
Мал сүрэг (өрхийн)			
Өрхийн дундаж	274	Мал	—
Хамгийн өндөр тохиолдол	903	Мал	—
Хамгийн бага тохиолдол	3	Мал	—
Ажил хөдөлмөр/эдийн засгийн үйл ажиллагаа			

²⁴ Орлогын эх үүсвэрийг тодорхойлж байхад цалин хөлс, тэтгэмжийн мэдээлэл байхгүй байсан.

Категори	Дүн	Нэгж	Эзлэх хувь, %
18-аас дээш насны хүн ам	256	Хүн	68% ²
Ажилгүй ³	79	Хүн	31% ⁴
65-аас дээш насны/тэтгэврийн	8	Хүн	2%
18-аас дээш насны оюутнууд	28	Хүн	11% ²

Эх сурвалж: Нөлөөлөлд өртсөн малчдын судалгаа, Оюу Толгой, 2011.

1. Судалгаанд оролцсон 84 өрхийн 72- оос нь найдвартай орлогын мэдээллийг цуглуулсан.
2. Хүн амын мэдээллийг насны ангилалаар харуулсан.
3. Ажилгүй хүмүүсийн тоонд өөрсдийгөө ажилгүй хэмээн бүртгүүлсэн малчин өрхийн гишүүдийг багтаасан. Эдгээр хүмүүсийн тоонд өрхийн эзэгтэй нар болон, мал маллахад идэвхтэй тусалдаг ч өөрсдийгөө идэвхтэй ажиллах хүч гэж тооцдоггүй 60-65 настай өндөр настанууд мөн багтсан.
4. Ажилгүйдлийн түвшинг тооцохдоо 18 болон түүнээс дээш насны судалгаанд хамрагдсан хүн амын ажилгүй гэж бүртгүүлсэн иргэдийн эзлэх хувиар тооцов.

9.6.5 Газар тариалан

Газар тариалангийн үйлдвэрлэл нь Ханбогд сумын иргэдийн амьжиргаанд чухал үүрэгтэй биш гэж хэлж болно. 2007 онд 1.5 га талбайд тариалалт хийсэн (төмс болон бусад хүнсний ногоо) ба энэ үзүүлэлт 2009 онд 0.5 га ²⁵ талбай болж буурчээ. 2009-2010 оны хатуу ширүүн өвлийн уршгаар газар тариалангийн талбай буурсан байна.

9.6.6 Жижиг бизнес

Бүртгэлтэй жижиг бизнес

2010 оны байдлаар Ханбогд суманд 95 хүн бүртгэлтэй жижиг бизнесийн байгууллагад ажиллаж байна. Хан дизель компани нь 15 ажилтантай, Хаан банк 7 ажилтантай байдаг нь хамгийн өндөрт тооцогдож байна (Хүснэгт 9.14). Эдгээр жижиг бизнесүүд нь сумын төвд төвлөрчээ. .

Хүснэгт 9.14: Бүртгэлтэй жижиг бизнесийн байгууллагууд ба ажиллагсдын тоо, 2010 он

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны төрөл	Ажилчдын тоо
1	Хаан Банк	Банк санхүү	7
2	Монгол Шуудан Банк	Банк санхүү	3
3	Хас Банк	Банк санхүү	5
4	Баян Бараат ШТС	Шатахууны худалдаа	2
5	НИК ШТС	Шатахууны худалдаа	2
6	Хан Жавхлант малын эмнэлэг	Малын эмнэлэг	1
7	Төрөлх Номгон	Малын эмнэлэг, эмийн худалдаа	1
8	Оргил дорж шуг	Эмийн худалдаа	2
9	Хан дизель	Дизель	15
10	МЦХ ХХК-ний салбар	Харилцаа холбоо	2
11	Монголын кабелийн сүлжээний салбар	Кабелийн үйлчилгээ	1
12	Дэгжих говь	Жолооны курс	2
13	Захиргааны буудал	ЗБ	2

²⁵ Ханбогд сумын засаг даргын тамгын газраас Оюу Толгой компани 2010 оны 03 сард цуглуулсан.

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны төрөл	Ажилчдын тоо
14	Дэлхийн энергийн төв	Жуулчны бааз	6
15	Оюут	Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа	4
16	3 тотго	Эсгий үйлдвэрлэл	2
17	Баянбогд	Нарийн боов/хүнсний дэлгүүр	4
18	Ханбогд хөгжил	Худалдаа, үйлчилгээ	6
19	Их Өлзийт Цагаан Уул	Хүнс, барааны дэлгүүр	3
20	Ханбулаг	Хүнс, барааны дэлгүүр, Мобикомын дистрибьютор	4
21	Говь	Хүнс, барааны дэлгүүр, Юнителийн дистрибьютор	3
22	Баян-Эрдэнэ	Хүнс, барааны дэлгүүр, Скайтелийн дистрибьютор	1
23	Уужим од	Хүнс, барааны дэлгүүр, ЗБ	6
24	Төлөгийн тал	Гэр ахуйн барааны дэлгүүр	2
25	Оргил	Хүнс, барааны дэлгүүр	3
26	3 бумт	Хүнс, барааны дэлгүүр	1
27	Итгэл баян	Хүнс, барааны дэлгүүр	1
28	Их булаг	Хүнс, барааны дэлгүүр, барилга	2
29	Далайн дуулга	Хүнс, барааны дэлгүүр	1
30	Ундрах	Хүнс, барааны дэлгүүр	1
31	Дархан өндөр богд	Эм, эмнэлгийн үйлчилгээ	1
32	Шүрэн тэмээ	Барилга засвар	1
33	Говь Сод Транс	Нүүрсний тээвэр, худалдаа	1
34	Өлзийт мөнх овоо	Оёдол, тээвэр, хими цэвэрлэгээ	3
35	Хан тээх	Тээвэр	1
Нийт ажилчдын тоо			95

Эх сурвалж: Өмнөговь аймгийн статистикийн хэлтэсээс 2010 онд Оюу Толгой мэдээллийг цуглуулсан

Хувиараа хөдөлмөр эрхлэлт буюу албан бус бизнес

Бүртгэлтэй жижиг бизнес эрхлэхийн зэрэгцээ, Ханбогд суманд 2010 оны мэдээгээр нийтдээ 50 гаруй иргэн хувиараа бизнес эрхлэдэг байсан байна. Эдгээр иргэд нь хувийн бизнестээ 66 хүнийг ажлын байраар хангадаг. Хүснэгт 9.15-д эдгээрийн төрлийг харуулав. Хувиараа эрхэлдэг бизнес нь ихэвчлэн хувь иргэн болон нэг гэр бүлийн хүмүүсээс бүрддэг ба улирлын чанартай байдаг. Ханбогд суманд албан бус хувийн бизнесүүд нь худалдаа, зоогийн газар, буудал, мужааны газар, тээврийн үйлчилгээ зэргээс бүрдэнэ. Хувиараа албан бусаар бизнес эрхлэх нь албан ёсоор орлогын бүртгэлд нь ордоггүй ч айл өрхийн орлогод ихээхэн хувь нэмэр оруулдаг байна.

Сумын иргэдийн хувьд жижиг бизнес эхлүүлэхэд хамгийн хүндрэлтэй асуудлууд нь санхүүжилт хүрэлцэхгүй байх, зээл авах бололцоо муу, орон нутгийн засаг захиргааны дэмжлэг хомс, цахилгаан эх үүсвэр дутмаг, бизнесийн үйл ажиллагаа явуулах байр савны хүрэлцээ муу зэрэг нөхцөлүүд байдаг байна. Жижиг бизнесийн дөрөвний гурав нь бизнесээсээ хангалттай орлого олж, бизнесээ өргөжүүлэх буюу өөр бизнес эхлүүлэх боломж хомс байдгийг судалгааны үеэр илэрхийлсэн. Хөдөөгийн малчид сумын төвийн иргэдийг бодвол хөрөнгө оруулалтын боломж

өндөртэй байдаг / малаа борлуулж санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх, илүү гэрээ улирлын чанартай кафе болгон ашиглуулах гэх мэт.²⁶

²⁶ ОТ төсөл, НЭЗБО-ны дэд судалгаа, 2009 он.

Хүснэгт 9.15: Ханбогд сумын хувиараа бизнес эрхлэгчид ба тэдгээрийн үйл ажиллагаа, 2010 оны 3-р сар

Үйл ажиллагааны төрөл	Ханбогд суманд үйл ажиллагаа явуулж буй	Ажиллах хүч
Блокны үйлдвэр	3	6
Газар тариалан	3	7
Талх, нарийн боов	2	4
Барилга	4	7
Монгол гэрийн засвар	4	5
Төмөр бүтээгдэхүүн	1	1
Гагнуур	6	6
Цахилгаан барааны засвар	3	3
Гахай, тахианы аж ахуй	3	5
Бусад	5	6
Бараа, бүтээгдэхүүн тээвэр	6	6
Гутал засвар	1	1
Дугуй засвар	2	2
Зорчигч тээвэр	6	6
Үсчин	2	2
Гоо сайханч	1	1
Нийт ажилах хүч		66

Ханбогд сумын засаг даргын тамгын газраас Оюу Толгой 2010 оны 03 сард цуглуулсан

Зарим малчид Цагаан Хад боомтын машины зогсоол орчимд албан бус бизнес эрхэлдэг байна. /Хүснэгт 9.16/ Мөн Жавхлант багийн төвд улирлын чанартай хүнсний дэлгүүр, кафе ажиллуулдаг. Ханбогд сумын зарим иргэд Гашуун Сухайт хилийн боомт дээр худалдаа хийж, Хятадын талаас барилгын материал болон бараа бүтээгдэхүүн импортоор оруулж ирэн борлуулдаг байна.

Хүснэгт 9.16: Ханбогд сумын төвөөс гадна байрладаг дэлгүүр, бизнесүүд, 2011

Ханбогд сумын төвөөс гадна байх дэлгүүр/бизнес	Нийт	Хүнс барааны дэлгүүр	Кафе
Цагаан хадны тээврийн зогсоол /хилийн боомт/ орчимд	5	3	2

Ханбогд сумын засаг даргын тамгын газраас Оюу Толгой 2011 онд цуглуулсан.

9.6.7 Төрийн албан хаагч

Ханбогд сумын төрийн байгууллагуудад 2010 оны сүүлээр нийт 145 хүн /42 эрэгтэй, 103 эмэгтэй/ ажиллаж байгаа нь 2009 оныхоос 2 хүнээр нэмэгджээ. Сумын төвд 13 төрийн байгууллага байдаг байна.

Хүснэгт 9.17: Ханбогд сумын төрийн байгууллагууд ба ажилтнууд, 2009, 2010 он

Төрийн байгууллага/ажилтнуудын хүйс	2009			2010		
	Нийт	эр	эм	Нийт	эр	эм
Сумын ЗДТГ	18	7	11	18	7	11
Дунд сургуулиуд	50	10	40	53	7	46

Төрийн байгууллага/ажилтнуудын хүйс	2009			2010		
	Нийт	эр	эм	Нийт	эр	эм
21-р цэцэрлэг	18	1	17	18	1	17
Эмнэлэг	22	1	21	22	1	21
Соёлын төв	6	2	4	5	2	3
ИТХ	2	1	1	2	1	1
Цаг уурын газар	5	1	4	5	1	4
Тусгай хамгаалалттай газрын захиргаа	4	4	0	4	4	0
Цагдаагийн хэлтэс	6	6	0	6	6	0
Баян багийн захиргаа	3	3	0	3	3	0
Номгон багийн захиргаа	3	3	0	3	3	0
Жавхлант багийн захиргаа	3	3	0	3	3	0
Гавилууд багийн захиргаа	3	3	0	3	3	0
Нийт	143	45	98	145	42	103

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэсээс 2010 онд Оюу Толгой мэдээлэл цуглуулсан

9.6.8 Уул уурхайн салбар

Оюу Толгой төсөл нь Ханбогд суманд хэрэгжиж буй уул уурхайн цорын ганц томоохон төсөл юм. 2010 оны эцэс гэхэд Ханбогд²⁷ сумын 629 иргэн Оюу Толгой болон түүний гэрээт гүйцэтгэгч байгууллагуудад ажилд орсон байна. Тэдний 346 нь эмэгтэй, 283 нь эрэгтэй юм. Оюу Толгойд ажиллаж буй эрэгтэй ажилчдын сарын дундаж цалин 438 ам.доллар бол эмэгтэй ажилчдынх 453 ам.доллар байдаг (71 эрэгтэй 31 эмэгтэй ажилчдаас авсан судалгааны үр дүн)²⁸.

Ханбогд сумаас ажилд орсон эмэгтэйчүүд Оюу Толгойн гэрээт гүйцэтгэгч байгууллагуудад цэвэрлэгээ, үйлчилгээний болон захиргааны ажлуудыг эрхэлж байна. Эрчүүд нь голдуу жолооч, биеийн хүчний болон харуул хамгаалалтын албанд ажилладаг. Хэд хэдэн иргэд мэргэжлийнхээ дагуу тус компанид ажилладаг байна.

9.6.9 Орлого ба зарлага

2008 оны Суурь судалгаанаас харахад Ханбогд²⁹ сумын нэг өрхийн сарын дундаж орлого нь 574,837 төгрөг (US\$383)³⁰ байна (Хүснэгт 9.18-г харна уу). Энэ дүн нь аймгийн дундаж үзүүлэлт болох 523,406 (US\$349) төгрөгөөс өндөр байгаа бөгөөд бодит мөнгөн орлогын хэмжээ нь 458,200 төгрөг (US\$305) байна. Өрхийн орлогын ихэнх хувийг цалин хөлс бүрдүүлдэг ба түүний дараагаар мал аж ахуй болон бусад жижиг бизнесээс олдог орлогууд орж байна. Хөдөө орон нутагт мал аж ахуй эрхлэх боломж их байдаг ч уул уурхайн салбарт ажиллагсад нь түүнээс хамаагүй өндөр хэмжээний цалин хөлс авдаг байна. Ханбогд суманд уул уурхайн салбарт ажиллаж буй иргэд мал аж ахуй, ой, загас агнуурын салбарт ажиллаж буй иргэдээс хоёр дахин их цалин хөлс авч байна. /Уул уурхайд дунджаар 267,000 төгрөгийг сард авч байгаа бол МАА болон бусад салбарт 132,000 төгрөгийг сард авдаг/.

Ханбогд сумын иргэд орлогынхоо 44 орчим хувийг нь хүнсний хэрэгцээндээ зарцуулж байгаа нь төслийн нөлөөллийн бүс нутаг дахь бусад сумдын дунджаас доогуур түвшинд байгаа юм. Орлогынхоо маш бага хувийг нь буюу 4.3%-ийг нь бараа материалд, 2.4%-г нь байр, халаалтад зарцуулж, үлдсэн 49%-г нь хүнсний бус бараа бүтээгдэхүүнд зарцуулж байна. Ханбогд сумын

²⁷ Ханбогд сумын хүн амын тоонд Монгол орны өөр аймаг сумаас ирж суурьшиж буй хүн амыг оруулаагүй болно.

²⁸ ОТ-н Хүний Нөөцийн Хэлтсээс авсан мэдээлэл

²⁹ Ханбогд сумын төвийн иргэд болон малчин өрхийг багтаасан .

³⁰ Валютын ханш \$USD = 1,500 төгрөг

иргэдийн 93% нь хэрэглээний бараа бүтээгдэхүүнээ орон нутгийн зах дээрээс авдаг бол 33% нь хэрэглээний бараагаа Хятадтай залгаа хилийн боомтоос, 8% нь Хятадаас худалдан авдаг байна. Ханбогд сум нь БНХАУ-тай хил залгаа байдаг учир тус сумын малчид хилийн боомтын худалдааны бүсээс хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан авах давтамж нь аймгийн дунджаас өндөр байдаг.

Хүснэгт 9.18: Ханбогд сумын өрхийн орлогын задаргаа (сараар), 2008 он

Үзүүлэлтүүд	Мөнгөний нэгж ₮
Өрхийн нийт орлого (сарын), ₮	574,837
Мөнгөн	458,200
Цалин	169,770
Тэтгэвэр тэтгэмж	50,599
МАН-н	146,794
Газар тариалангийн	46
Гэр бүлийн бизнесийн	90,991
Мөнгөн бус /бэлэг, өөрсдийн хүнсээ бэлдсэн зэрэг/	116,637
Өөрийн бизнесийн орлого	% (дундаж)
Дундаж	13.3
Сумын төвд	17.7
Хөдөөд	6.3
Нэг хүнд ноогдох зарлага (сарын), ₮	146,370
Хүнсний бүтээгдэхүүн	52,820
Өргөн хэрэглээний бараа	7,183
Дулаан, байр	2,987
Хүнсний бус бүтээгдэхүүн	83,380

ОТ төсөл, НЭЗБО-ны дэд судалгаа, 2009 он.

9.6.10 Нэмэлт орлого

Суурь судалгаанаас харахад, Ханбогд сумын нийт хүн амын 62.4% нь банкнаас зээл авч байсан байна. 2007 онд сумын төвийн иргэдийн 59.7% нь, малчдын 66.7% нь банкнаас зээл авчээ. Зээлийн зориулалтын талаарх мэдээллийг Хүснэгт 9.19-т харуулав.

Хүснэгт 9.19: Зээлийн зориулалт, судалгаанд оролцогсдын %, 2008

Сумын нэр	ХАА	Мал аж ахуй	Худалдаа	Өрхийн үйлдвэрлэл	Орон сууц барих	Гэр бүлийн хэрэгцээнд	Бусад
Баян-Овоо	0.0	22.7	9.1	4.5	0.0	40.9	45.5
Манлай	0.0	0.0	11.4	8.6	2.9	77.1	2.9
Ханбогд	0.0	11.8	16.2	11.8	7.4	54.4	0.0
Цогтцэций	4.8	2.4	11.9	4.8	0.0	76.2	0.0
Даланзадгад	0.6	3.4	18.0	10.1	9.6	64.6	7.3
Аймгийн дундаж	3.3	9.6	13.3	8.2	5.1	62.5	8.2

Оюу Толгой төсөл, НЭЗБО-ны суурь судалгаа (дэд багц), 2009 он

Ханбогд сумын иргэд төслийн нөлөөллийн бүсийн бусад сумын иргэдийн нэгэн адил ихэвчлэн арилжааны банкнаас зээл авдаг (Хүснэгт 9.20 –г харна уу) бөгөөд гэр бүл, хувь хүнээс мөн зээл авдаг байна.

Хүснэгт 9.20: Зээлдүүлэгчдийн төрөл, судалгаанд оролцогсдын %, 2008 он

Сумын нэр	Арилцааны банк	Бусад
Баян-Овоо	100.0	0.0
Манлай	94.3	5.7
Ханбогд	98.5	1.5
Цогтцэций	88.1	11.9
Даланзадгад	91.0	9.0
Аймгийн дундаж	92.9	7.1

ОТ төсөл, НЭЗБО-ны дэд судалгаа, 2009 он

Зээл авсан хүмүүсийн ихэнх нь малчид байгаагийн учир нь тэдэнд тогтмол орлого байдаггүйтэй холбоотой. Судалгаанд хамрагдсан сум, аймгийн төвийн иргэдийн талаас илүү хувь нь тэдний барьцааны хөрөнгө нь банкны зээлийн шаардлагыг хангадаггүй, зээлийн хүү өндөр, зээлийн хугацаа богино зэрэг шалтгааныг дурьдсан байна. Малчдын хувьд зээл нь сайн хөрөнгө оруулалт болж чаддаггүй.

Орлогын бусад нэмэлт эх үүсвэрүүд нь нийгмийн халамжийн тэтгэмж, өндөр насны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж зэргээс бүрддэг. Өмнөговь аймгийн Статистикийн газрын мэдээгээр, 2010 оны 03 сарын байдлаар Ханбогд сумын 37 иргэн улсаас нийгмийн халамжийн тэтгэмж авч байсан байна.

9.6.11 Эдийн засгийн эмзэг бүлэг

2011 оны байдлаар Ханбогд сумын захиргааны ангилснаар нийтдээ 81 өрхийн 283 иргэн ядуурлын түвшингээс доогуур амьдралтай байна.³¹ Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн тодорхойлсноор 15 өрхийн 73 иргэн нэн эмзэг бүлэгт хамаарагддаг байна. Тиймээс Оюу Толгой эдгээр эмзэг бүлгийн иргэдийн ахуй амьдралд туслах талаар сумын захиргаатай хамтран ажиллаж байгаа бөгөөд тэднийг хэлэлцүүлэгт хамруулах болон төслийн үр ашгаас хүртэх боломжоор хангахыг чармайн ажиллаж байна. Тус компаний Олон нийт болон нийгмийн асуудал эрхэлсэн хэлтсээс эмзэг бүлгийн иргэдийн дунд судалгаа явуулж байгаа бөгөөд төслийн нөлөөлөлд өртсөн малчдын дунд эмзэг бүлгийн айл өрх хэр олон байгаа талаарх мэдээлэл 2011 оны 6-р сард гарна.

9.7 ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖЛУУД

2011 онд Ханбогд сумын хүрээнд хэд хэдэн нэмэлт судалгааг одоогийн нийгмийн суурь судалгааны баримт мэдээллийг сайжруулах үүднээс явуулсан. Ялангуяа энэхүү судалгааны ажил нь сумын хэмжээн дэхь эмзэг иргэдийг тогтоох талаар анхаарсан байна. Эдгээр судалгаагаар нийт 55 айл өрхийг (14 нь төслийн зүгээс нөлөөлөлд шууд өртөж буй малчин айл өрх юм) эмзэг бүлэг хэмээн тодорхойлсон ба үр дүнг олон нийтэд ил гаргасан байгаа.

Түүнчлэн шууд нөлөөлөлд өртөж буй 84 (нийт айл өрхүүдийн 7.5%) айл өрхөөс судалгаа авсан. Ажил хайгчдын дунд явуулсан судалгаагаар ур чадварын шалгалтыг мөн хийсэн.

Олон нийт болон нийгмийн асуудал эрхэлсэн хэлтэс нь сумын иргэдээс орлоготой холбоотой болон бусад нийгэм эдийн засгийн судалгааг үргэлжлүүлэн хийнэ . Үүнд:

- Малчин өрхүүдийн сумын төвд шилжин суурьшиж буй хандлага болон үүнтэй уялдан сумын хэмжээнд байгаа эзэнгүй өвөлжөөний тоо;

³¹ Хөдөлмөр Хамгаалал Нийгмийн Үйлчилгээний ажилтанаас 2011 оны 6-р сард Оюу Толгойнн цуглуулсан

- Сумын хэмжээнд цалинтай хөдөлмөр эрхэлдэг иргэд ба газраас хамааралтай (цалингүй) ажиллаж буй иргэдийн тооны хоорондын харьцаа ;
- Малчин болон малчин бус өрхүүдийн янз бүрийн үйл ажиллагаанаас олж буй орлогын түвшин;
- Айл өрхүүдийн ба хувь иргэдийн хөдөө болон суурин газарт амьжиргаагаа дээшлүүлэх зорилготой явуулж буй үйл ажиллагааны тоо, төрөл зүйл /уул уурхай, уул уурхайтай холбоотой болон бусад салбар дахь хөдөлмөр эрхлэлтүүдийг багтаасан/;
- Сумын төвд амьдардаг малтай айл өрхийн эзлэх хувь, мал сүргээ бусдаар маллуулдаг байдал;

Цаашид төлөвлөсөн ажлын ихэнх нь айл өрхийн орлоготой холбоотой судалгаа юм. Оюу Толгой төслийн хүрээнд явагдах эдийн засгийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо болон өртөх эмзэг бүлгийнхний оролцооны талаар Олон нийт болон нийгмийн асуудал эрхэлсэн хэлтэс үнэлгээ хийх үүднээс цаашид хийгдэх нарийвчилсан буюу нас, хүйс, орлогоор ангилсан судалгааг явуулах болно.

Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө OTESIA@ot.mn хаягаар ирүүлнэ үү.